

*Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 7601 дүгээрт бүртгээ*

## **БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГЫН ХАМТАРСАН ЗАХИРАМЖ, ТУШААЛ**

2026 оны 4 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар А/255, А/84

Номгон

### **ЗОЛБИН НОХОЙ, МУУРЫГ ХОТ, СУУРИН ГАЗАРТ ГАЛТ ЗЭВСЭГ АШИГЛАН УСТГАХ ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, Захиргааны ерөнхий хуулийн 64 дүгээр зүйлийн 64.1, Гэрийн тэжээвэр амьтны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1, Галт зэвсгийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 11.3 дахь хэсгийг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ, ТУШААХ НЬ:

1.Иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах хүрээнд “Золбин нохой, муурыг хот, суурин газарт галт зэвсэг ашиглан устгахад мөрдөн ажиллах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Сумдын Засаг дарга нарт, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга, дэд хурандаа (Т.Цэдээндорж)-т тус тус үүрэг болгосугай.

3.Журмыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгүүлэх арга хэмжээ авч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль эрх зүйн хэлтсийн дарга (Д.Сарангарав)-т үүрэг болгосугай.

3.Журмыг захиргааны хэм хэмжээний актын нэгдсэн санд бүртгэгдсэн өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй

4.Аймгийн Засаг дарга, Цагдаагийн газрын даргын хамтарсан 2025 оны А/359, А/85 дугаар захирамж, тушаалыг хүчингүй болгосугай.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

Э.ЭНХБАТ

ЦАГДААГИЙН ГАЗРЫН ДАРГА

Т.ЦЭВЭЭНДОРЖ



*Аймгийн Засаг дарга, Цагдаагийн газрын даргын 2026 оны  
4 дүгээр сарын 27-ны өдрийн А/255, А/84 дүгээр  
захирамж, тушаалын хавсралт*

**ЗОЛБИН НОХОЙ, МУУРЫГ ХОТ, СУУРИН ГАЗАРТ  
ГАЛТ ЗЭВСЭГ АШИГЛАН УСТГАХАД  
МӨРДӨН АЖИЛЛАХ ЖУРАМ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1.Баянхонгор аймгийн нутаг дэвсгэрт сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газраас золбин нохой, муурыг сумын төв, суурин газарт галт зэвсэг ашиглан устгахтай холбоотой харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Энэхүү журам нь Галт зэвсгийн тухай хууль, бусад хууль тогтоомжид нийцсэн байна.

1.3.Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Гэрийн тэжээвэр амьтны тухай хууль, Галт зэвсгийн тухай хууль, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгоно.

**Хоёр. Зохион байгуулалт**

2.1.Хот, суурин газарт золбин нохой, муурыг галт зэвсэг ашиглан устгах ажлыг Баянхонгор сумын Засаг дарга, Цэвэр хот ОНӨААТҮГ-тай хамтран, бусад сумдад тухайн сумын Засаг дарга тус тус зохион байгуулна.

2.2.Золбин нохой, муур устгах ажлыг зохион байгуулах талаар сумын Засаг дарга шийдвэр гаргана.

2.3.Сумын Засаг даргын гаргасан шийдвэрийг үндэслэн сумын Засаг даргын Тамгын газар, зарим сумдад Захирагчийн ажлын алба устгах ажлыг мэргэжлийн байгууллагатай хамтран зохион байгуулна.

2.4.Устгалыг жилд хоёроос доошгүй удаа, шаардлагатай тохиолдолд тухай бүр зохион байгуулна

2.5.Устгал зохион байгуулах ажлыг аймгийн Цагдаагийн газарт, шаардлагатай тохиолдолд Тагнуулын байгууллагад мэдэгдэж ажиллана.

2.6.Золбин нохой, муурыг галт зэвсэг ашиглан устгах гэрээнд ашиглах галт зэвсгийг жил бүр /цагдаагийн байгууллагад/ тооллогод хамруулах, сумыг холбогдох зөвшөөрөл бүхий хуулийн этгээдээс худалдан авч байх талаар тусгасан байх бөгөөд Цагдаагийн газар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч, хяналт тавьж ажиллана.

### **Гурав.Аюулгүй ажиллагаа,**

3.1.Иргэд олон нийтэд нохой устгахтай холбоотой мэдээллийг 7 хоногийн өмнө хэвлэл мэдээллийн хэрэгслээр зарлана.

3.2.Устгалын хугацааг тодорхой зааж, иргэдийн аюулгүй байдлыг хангах зохион байгуулалтын арга хэмжээг аймгийн Цагдаагийн газар, сум, багийн Засаг дарга, устгах иргэн, аж ахуйн нэгж хамтран хэрэгжүүлнэ.

3.3.Устгалын явцад аливаа эрсдэл үүссэн тохиолдолд хуулийн байгууллагад шуурхай мэдэгдэх

#### **Дөрөв. Золбин нохой, муурыг устгах иргэнд тавигдах шаардлага**

4.1.Золбин нохой, муурыг устгах иргэн нь Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан 21 нас хүрсэн, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, галт зэвсэг ашиглаж гэмт хэрэг санаатай үйлдэж байгаагүй, галт зэвсэг эзэмших, ашиглах, хадгалах аюулгүй ажиллагааны сургалтад хамрагдаж гэрчилгээ авсан Монгол Улсын иргэн байна.

4.2.Иргэн нь мөн хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсэгт заасны дагуу галт зэвсгээ бүртгүүлж, галт зэвсгийн гэрчилгээ авсан байна.

#### **Тав.Талуудын эрх, үүрэг**

5.1.Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын эрх, үүрэг

5.1.1.Золбин нохой, муурыг устгах талаар зохион байгуулсан сумын Засаг даргын ажлын тайланг хэлэлцэх, гүйцэтгэлд хяналт тавих;

5.1.2.Сумын Засаг даргын саналд үндэслэн золбин нохой, муур устгах ажилд шаардагдах төсвийг батлах, нохой, муур устгах үнэлгээг тогтоох.

5.2.Сумын Засаг даргын Тамгын газрын эрх, үүрэг

5.2.1.Сумын төв, суурин газрын золбин нохой, муурын судалгааг жил бүр гаргаж, устгах тоог тогтоож, холбогдох мэргэжлийн байгууллага (Мал эмнэлгийн газар, Байгаль орчны газар)-д танилцуулах;

5.2.2.Журмын 2.3 дахь хэсэгт заасан үйл ажиллагааг зохион байгуулах;

5.2.3.Сумдын Засаг даргын Тамгын газар, зарим сумын Захирагчийн ажлын алба нь Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт заасан шалгуурыг хангасан мэргэшсэн, туршлагатай иргэн эсхүл тэдний оролцоотой баг, хуулийн этгээдийг сонгож, тухайн «Сумын төв, суурин газарт золбин нохой, муурыг галт зэвсэг ашиглан устгах гэрээ» байгуулан золбин нохой, муурыг галт зэвсэг ашиглан устгах ажлыг гүйцэтгүүлэх;

5.2.4.Журмын 5.2.3-т заасан гэрээнд золбин нохой, муурыг устгахад ашиглах галт зэвсэг нь Галт зэвсгийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2-т заасан шалгуурыг хангасан, жил бүр тооллогод

хамруулсан, сумыг холбогдох зөвшөөрөл бүхий газраас худалдан авах, аюулгүй байдлыг хангах талаар болон бусад асуудлыг харилцан тохиролцож тусгах;

5.2.5. Гэрээнд заасны дагуу иргэнд устгасан золбин нохой, муур нэг бүрд ногдох мөнгөн урамшууллыг олгох;

5.2.6. Устгасан золбин нохой, муурыг хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол хүн амын суурьшлын бүсээс хол, хогийн цэг, бусад зориулалтын газарт Мал эмнэлгийн хяналтад зөөвөрлөж булж устгах, халдваргүйжүүлэх арга хэмжээ авах;

5.2.7. Устгалын тайланг хагас, бүтэн жилээр гаргаж аймгийн Засаг даргын Тамгын газар, Цагдаагийн газарт тус тус хүргүүлэх;

5.2.8. Золбин нохой, муурыг устгах гэрээ байгуулсан иргэн, хуулийн этгээдийн талаарх мэдээллийг аймгийн Цагдаагийн газарт нэн даруй гарган өгч, аюулгүй байдлын баталгаа, зааварчилгаа авах;

5.2.9. Иргэдэд мэдээлэл хүргэж устгалын цагаар иргэдийн аюулгүй байдлыг хангах талаар хөдөлгөөнийг зохицуулах;

#### 5.3. Багийн Засаг даргын эрх, үүрэг

5.3.1. Золбин нохой, муурын тоо, судалгааг гаргаж сумын Засаг даргын Тамгын газарт хүргүүлж байх;

5.3.2. Багийн нутаг дэвсгэр дэх золбин нохой, муурыг устгуулах саналаа гаргаж устгал зохион байгуулах үед хамтран оролцох, зохион байгуулах;

5.3.3. Хууль тогтоомжийн хүрээнд аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын тогтоосон тэжээвэр нохой, муур, амьтны татвар, төлбөр, хураамжийг төлүүлэх ажлыг багийн хэмжээнд зохион байгуулах.

#### 5.4. Цагдаагийн газрын эрх, үүрэг

5.4.1. Аймаг, сумдын төв, суурин газарт галт зэвсэг ашиглан золбин нохой, муурыг устгах ажилд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, журмыг хэрэгжүүлэх ажилд хяналт тавих;

5.4.2. Галт зэвсгийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан иргэнийг гэрээгээр ажиллуулж буй эсэхэд хяналт тавих;

5.4.3. Иргэн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомж болон галт зэвсэг, ангийн хэрэгсэлтэй ажиллах аюулгүй ажиллагааны зааварчилгааг өгч ажиллах, биелэлтэд хяналт тавих;

5.4.4. Иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд шалгалт хийж, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, шаардлагатай гэж үзвэл гэрээг цуцлах саналыг холбогдох байгууллагад хүргүүлэх;

5.4.5. Аймгийн төв, суурин газар (сумын төв)-т галт зэвсэг ашиглан золбин нохой, муурыг устгахтай холбоотойгоор иргэн, аж

ахуйн нэгжийн гэрээ, галт зэвсэг, сумны талаарх мэдээлэл бусад шаардлагатай баримт бичигтэй танилцах, шалгах, хяналт тавих;

5.4.6.Иргэн, хуулийн этгээдэд энэхүү журмаар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэн ажиллах талаар Мэдэгдэл хүргүүлэх, биелэлтийг тооцох;

5.4.7.Устгалын тайланг хагас, бүтэн жилээр гаргуулан авах.

5.5.Нохой, муур устгах иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

5.5.1.Золбин нохой, муурыг устгах ажлыг гэрээ байгуулан гүйцэтгэх, холбогдох санхүүжилт, урамшууллыг авах;

5.5.2.Агнах арга, цаг хугацаа, техник хэрэгслээ орон нутгийн онцлог, нөхцөл байдалд тохируулан зөв сонгох, золбин нохой, муурыг устгах үйл ажиллагааг аюулгүй байдлыг бүрэн хангасан тохиолдолд явуулах;

5.5.3.Устгалтыг зохион байгуулахдаа дуу намсгагчтай дурантай буу ашиглан, иргэд харах боломжгүй байршилд буудлага үйлдэх,

5.5.4.Устгалын ажил явуулахын өмнө нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагад биечлэн ирж холбогдох гэрээ, галт зэвсэг, сумны талаарх мэдээлэл (бууны гэрчилгээ, зохих зөвшөөрөл бүхий газраас сум, хэрэгсэл худалдан авсан тухай баримт) бусад бичиг баримтыг танилцуулж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа авах;

5.5.5.Агнасан золбин нохой, муурыг цаг тухай бүрд нь хүлээлгэн өгч холбогдох тооцоог хийх, устгалын ажлын тайланг сумын Засаг даргын Тамгын газарт тухай бүр гаргаж өгч байх.

5.6.Иргэний үүрэг

5.6.1.Нохой, муурыг вакцинжуулах, мал амьтнаас хүнд халдварладаг өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах;

5.6.2.Нохой, муурыг зэрлэгшүүлэхгүй байх;

5.6.3.Нохой, муурыг хараа хяналтад байлгаж, бусдад гэмт хор учруулахгүй байх;

5.6.4.Тэжээвэр амьтан нохой, муурыг хүзүүвчтэй байлгах;

5.6.5.Нохой, муур, мал, тэжээвэр амьтныг тэнэмэл, золбин болгох, хаяж гээхгүй байх;

5.6.6.Золбин нохой, муурын талаарх мэдээллийг сум, багийн Засаг даргад мэдэгдэж байх;

### **Зургаа.Санхүүжилт**

6.1.Золбин нохой, муурыг устгах ажилд шаардагдах зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

### **Долоо.Хариуцлага**

7.1.Иргэн, хуулийн этгээд гэрээгээр хүлээсэн үүргээ хангалтгүй биелүүлсэн, галт зэвсгээр сум алдаж бусдын амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулсан бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

## НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2026 оны 4 дүгээр  
сарын 27-ны өдөр

Дугаар А/623

Улаанбаатар  
хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.3 дахь заалт, 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.1, 35.1.5 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2017 оны 195 дугаар тушаалаар баталсан “Барилгын ажлын аюулгүй ажиллагааны Үлгэрчилсэн журам”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Барилгын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах “Нийслэл дэх барилгын ажлын аюулгүй ажиллагааны журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Нийслэл Улаанбаатар хотын хэмжээнд барилгын үйл ажиллагаа эрхэлж буй иргэн, хуулийн этгээдэд журмыг сурталчлан таниулах, мөрдүүлэх, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (С.Энхбаяр)-т, дүүргүүд дэх Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний хэлтсийн дарга нарт үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг даргын эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч (Т.Даваадалай)-д даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА  
БӨГӨӨД УЛААНБААТАР  
ХОТЫН ЗАХИРАГЧ

Х.НЯМБААТАР



*Нийслэлийн Засаг даргын 2026 оны  
4 дүгээр сарын 27-ны өдрийн  
А/623 дугаар захирамжийн хавсралт*

**НИЙСЛЭЛ ДЭХ  
БАРИЛГЫН АЖЛЫН АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЖУРАМ**

**Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Энэ журмын зорилго нь барилгын ажлын явцад гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх, ажлын талбай эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрдүүлэх, хяналт тавих, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлагыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

1.2.Журмын зохицуулалт нь Иргэний хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Барилгын тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акттай нийцсэн байна.

1.3.Энэ журмыг Нийслэл Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт барилга байгууламж бариулж буй барилгын ажлын захиалагч, зураг төсөл зохиогч, барилга, байгууламж (өргөх байгууламж, инженерийн шугам сүлжээ)-ийн зураг төсөлд магадлал хийх эксперт, барилгын ажил гүйцэтгэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, барилгын материал үйлдвэрлэгч, ханган нийлүүлэгч, барилгын салбарын ажилтан, барилга байгууламжийг өмчлөгч, эзэмшигч, барилга байгууламжийн техникийн улсын хяналтыг хэрэгжүүлэгч этгээд болон бусад барилгын үйл ажиллагаанд оролцогчид өмчийн хэлбэр харгалзахгүйгээр дагаж мөрдөнө.

1.4.Барилгын үйл ажиллагаанд оролцогч нь холбогдох хууль, тогтоомж болон Монгол Улсын барилгын норм ба дүрэм, үндэсний ба хотын стандартыг хэрэгжүүлбэл зохино.

1.5.Энэ журмаар зохицуулагдаагүй бусад харилцааг холбогдох хууль тогтоомжоор зохицуулах бөгөөд журамд тусгагдсан нэр томьёог холбогдох хууль тогтоомжид заасан утгаар ойлгоно.

**Хоёр.Барилгын ажлын зохион байгуулалтад тавих хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага**

2.1.Барилгын ажлын байр, талбай эрсдэл бүхий гадна орчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах, аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг хөрөнгө оруулагч, захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч хариуцан хэрэгжүүлнэ.

2.2.Барилгын ажлын байр, талбай эрсдэл бүхий гадна орчны аюулгүй байдлыг барилгын ажлын зохион байгуулалт, технологийн

үйл ажиллагаатай нь уялдуулж хангах талаар дараах баримт бичигт заавал тусгана:

2.2.1.цогцолбор барилга байгууламж, хороолол, бичил хорооллын хувьд барилгын зохион байгуулалтын төсөл;

2.2.2.тухайлсан барилгын хувьд ажил гүйцэтгэх төсөл;

2.2.3.байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ;

2.2.4.барилгын талбайгаас газрын доорх ус шавхан зайлуулах бол ус ашиглуулах дүгнэлт.

2.3.Энэ журмын 2.2.1-д заасан цогцолбор барилга байгууламж, хороолол, бичил хорооллын барилга байгууламжийн “Барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг”, “Барилгын ажлын талбайд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар”-ыг захиалагч боловсруулж, батална.

2.4.Энэ журмын 2.2.2-т заасан тухайлсан барилга байгууламжийн “Барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг”, “Барилгын ажлын талбайд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар”-ыг гүйцэтгэгч боловсруулж, захиалагчтай хамтран батална.

2.5.“Барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг”, “Барилгын ажлын талбайд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар”, “Барилгын үйлдвэрлэлийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Техникийн аюулгүй ажиллагааны дүрэм”, “Галын аюулгүй байдлын үндсэн дүрэм”-ийг хөрөнгө оруулагч, захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэхээс барилга байгууламжийг ашиглалтад оруулах хүртэл хугацаанд дагаж мөрдөнө.

2.6.Хороолол бичил хорооллын дунд барилгын ажил гүйцэтгэхдээ тухайн орчинд ажиллаж, амьдарч байгаа иргэдийн орчны аюулгүй байдлыг хангуулах, нийтийн эзэмшлийн зам талбайг ашиглах, замын орц, гарцыг хаах зэрэг асуудлыг захиалагч зохих журмын дагуу эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авна. Хэрэв нийтийн эзэмшлийн зам талбай, тухайн орчныг сүйтгэсэн тохиолдолд дахин сэргээн засварлах, шинэчлэх ажлыг бүрэн хариуцна.

2.7.Захиалагч гүйцэтгэгчтэй хамтран барилгын ажил эхлэхийн өмнө тухайн барилгын үйлдвэрлэлийн үйл ажиллагааны эрсдэлийн ерөнхий үнэлгээг хийж, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө”-нд шаардлагатай санхүүжилтийн зардлыг тооцож гаргасан байна.

2.8.Энэ журмын 2.7-д заасан зардалд барилгын ажлын талбайн зохион байгуулалт, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны зардлаас гадна дараах зардлыг заавал тусгана.

2.8.1.Барилгын түр хашааны стандартын дагуу барилгын гадна хашаа, шат, өндрөөс унах аюулаас хамгаалах тор, хаалт, татлага, ажилчдын ахуйн байр, аюулгүйн бүсийг тогтоох хашлагын хамгаалалтын зардал;

2.8.2.“Барилгын төсөв зохиох дүрэм”-д тусгасан барилгын ажилчдын хөдөлмөрийн багаж хэрэгсэл, ажлын хувцас, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээний болон нэмэгдэл зардал.

2.9.Барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчинд гарч болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх зорилгоор ажлын байрны эрсдэлийн үнэлгээг дараах нөхцөлд хийнэ:

2.9.1.барилгын үе шатны ажил эхлэхийн өмнө ажилбар бүрд;

2.9.2.дотоод хяналтаар зөрчил илэрсэн тухай бүрд;

2.9.3.ажлын байр өөрчлөгдөх бүрд;

2.9.4.туслан гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээт ажил эхлэх бүрд;

2.9.5.шинэ технологи, арга барил, материал, бодис хэрэглэх бүрд;

2.9.6.үйлдвэрлэлийн осол, гэмтэл гарах бүрд;

2.9.7.хууль тогтоомжид заасан бусад.

2.10.Энэ журмын 2.9.1-д заасан үнэлгээг ерөнхий гүйцэтгэгчийн талбайн инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан, мөн журмын 2.9.2, 2.9.4-д заасан үнэлгээг ерөнхий болон туслан гүйцэтгэгчийн тухайн асуудал хариуцсан инженер тус тус хариуцан гүйцэтгэнэ.

2.11.Эрсдэлийн үнэлгээг хийхдээ тухайн ажлын байранд ажиллаж байгаа ажилтныг заавал оролцуулна.

2.12.Гүйцэтгэгч үйл ажиллагааны эрсдэлийн түвшин болон барилгажих төслийн хэмжээнээс хамаарч 1-ээс дээш орон тооны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан ажиллуулах бөгөөд Эрүүл ахуйн тухай хуулийн 13.1.9-д заасан 50 ба түүнээс дээш ажилтантай үйлдвэр, үйлчилгээний байгууллага, аж ахуйн нэгж нь эрүүл ахуй, хөдөлмөрийн аюулгүй байдал хариуцсан ажилтныг эрүүл мэндийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагуудаас баталсан журмын дагуу ажиллуулна.

2.13.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн баг, ажилтан холбогдох сургалтад хамрагдаж дараах чадварыг эзэмшиж, мэргэшсэн байна. Үүнд:

2.13.1.ажлын байранд болзошгүй аюул, осол гарах нөхцөлийг мэддэг байх;

2.13.2.ажлын нөхцөл нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан эсэхийг шалгаж, илрүүлэх чадвартай байх;

2.13.3.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах шуурхай арга хэмжээг авч хэрэгжүүлэх чадвартай байх;

2.14.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн баг, ажилтан энэ журмын 2.7-д заасан төлөвлөгөөний дагуу аюулгүй ажиллагааны сургалт, ажлын байрны үзлэг, шалгалтыг барилгын үе шатны ажилтантай уялдуулан долоо хоног, сар, улирлаар төлөвлөж гүйцэтгэнэ.

2.15.Энэ журмын 2.7-д заасан ажлыг гүйцэтгэхтэй холбогдон гарах зардлыг гүйцэтгэгчийн эрх бүхий ажилтан тухай бүр баталж, зарцуулна.

2.16.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 27.5-д зааснаар аж ахуйн нэгж байгууллагын хэлтэс, албаны дарга, нэгж, тасгийн ахлагч болон тэдгээртэй адилтгах албан тушаалтнууд болох талбайн болон хэсгийн инженер (цахилгааны, механик, сантехникийн), бригадын дарга, ахлах тогооч, ахлах нярав, харуулын ахлах нь өөрийн удирдлагад ажилладаг нийт ажилтнуудад өдөр тутам аюулгүй ажиллагааны зааварчилгааг холбогдох стандартын дагуу өгч гарын үсэг зуруулж баталгаажуулна.

2.17.Давтан зааварчилгааны агуулга нь тухайн ажилтны ажлын байрны үйлдвэрлэлийн процесс, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл ашиглах болон ажлын явцад үүсэж болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, аюулгүйн ажиллагааны арга барил, үйлдвэрлэлийн өргөх, тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах, журам, гал түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод үзүүлэх анхан шатны тусламж зэрэг ба үүгээр үл хязгаарлагдах асуудлууд болно.

2.18.Ажилтны ажлын байр өөрчлөгдөх үед болон шинээр орсон ажилтан, үйлдвэрлэлийн дадлагажигч, оюутанд мөн стандартын агуулгаар ажлын байрны анхан шатны зааварчилгаа өгөх ба зааварчилгаа өгсөн ажилтан шалгалт авч хангалттай гэж үзвэл уг ажилтанд бие даан ажиллах зөвшөөрөл олгоно.

2.19.Ажлын байран дахь анхан шатны зааварчилгааны агуулга нь ерөнхий мэдлэг олгох буюу хөдөлмөрийн хууль, тогтоомж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журам, заавар, стандарт, тухайн ажилтны ажлын байрны үйлдвэрлэлийн процесс, гүйцэтгэх ажлын онцлог, машин техник, багаж, хэрэгсэл ашиглах болон ажлын явцад үүсэж болох сөрөг хүчин зүйл, түүнээс хамгаалах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, аюулгүйн ажиллагааны арга барил, үйлдвэрлэлийн өргөх, тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой, цахилгаан тоног төхөөрөмжийн ашиглалт, аюулгүй ажиллагааны шаардлага, галын аюулгүй байдлыг хангах, журам, гал

түймэр гарсан үед авах арга хэмжээ, гал унтраах хэрэгсэл, тэдгээрийг ашиглах, хадгалах, осолдогчдод үзүүлэх анхны тусламж зэрэг болно.

2.20. Зааварчилгаа өгсөн байдал, анхан шатны албан баримт бичиг болох зааврын агуулга, боловсруулсан байдалд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан шуурхай хяналт тавьж, мэргэжлийн зөвлөгөө, тусламж үзүүлэн зөрчлийг арилган хамтран ажиллана.

2.21. Ажлыг аюулгүй гүйцэтгэхэд мөрдөх аюулгүй ажиллагааны зааврыг барилгын талбайд байрлуулсан арматур боловсруулах бүх төрлийн тоног төхөөрөмж, ширээ хөрөө, шавар зуурагч, барилгын ирмэг задгай хэсэг, бүх төрлийн давхар хоорондын шат ба түүний хонгил, ажилтнуудын зорчих хэсгүүд, эдгээрээр үл хязгаарлагдах үйлдвэрлэлийн аюултай ба хортой хүчин зүйлийн үйлчлэл бүхий газруудад ажилтнуудын нүдэнд ил харагдахуйц, тодорхой байдлаар А4 форматаас багагүй хэмжээгээр хэвлүүлэн, анхааруулах, хориглох, сануулах, заах зэрэг холбогдох санамж тэмдгийн хамт байрлуулна.

2.22. Захиалагчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй хариуцсан ажилтнууд гүйцэтгэгчийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн хууль тогтоомж, стандартын шаардлага хэрхэн хэрэгжиж буйд шуурхай хяналт тавьж, хууль, тогтоомжийн хүрээнд нийцүүлсэн дотоод журмын дагуу шаардлага хүргүүлж ажиллана.

2.23. Захиалагч, гүйцэтгэгч барилгын ажлын зохион байгуулалтад тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагатай холбоотойгоор дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

2.23.1. Аюулгүй ажиллагааны өдөр тутмын хяналт хийхийн зэрэгцээ барилгын хэв хашмал, төрөл бүрийн шат, өргөх зөөх механизм, гэрэлтүүлэг, хашлага хамгаалалт, тэмдэг, санамж, ажлын хувцас, нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, галын аюулгүй байдал, гамшгаас хамгаалах бэлэн байдал, инженерийн байгууламж, эдгээрээр үл хязгаарлагдах чиглэлээр аюулгүй ажиллагааны зорилтот хяналтыг сар тутам хийж баталгаажуулан, хяналтын үр дүнгээр бүрэн бүтэн, найдвартай байдлыг хангах, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч ажиллана.

2.24. Захиалагч, гүйцэтгэгч нар Эрүүл ахуйн тухай хууль, Улаанбаатар хотын стандарт (UCS 1706A:2022 Хог хаягдлын менежмент)-д тус тус заасан шаардлагуудыг бүрэн хэрэгжүүлж, барилгын төрөл бүрийн хог хаягдлыг цуглуулах, ангилах, тээвэрлэх, устгах үйл ажиллагааг зохион байгуулна. Барилгын материал болон хог хаягдлыг ачааны машины тэвшин дээр ачихдаа зориулалтын бүтээлэг, бэхлэлт хийн замын хөдөлгөөнд оролцоно.

2.25. Захиалагч болон гүйцэтгэгч нь энэ журмын 2.11, 2.18-д заасан чиг үүргийг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг

хариуцан ажилладаг зөвлөх үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдээр гүйцэтгүүлж болно.

### **Гурав.Барилгын ажил эхлэхийн өмнө тавих хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага**

3.1.Барилгын ажил эхлэхийн өмнө барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчинд дараах шаардлагыг хангасан байна:

3.1.1.Барилгын ажлын талбайд ашиглах тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн жагсаалтыг гаргаж, аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж батлах, мэргэшсэн ажилтныг сургаж бэлтгэсэн байх;

3.1.2.Барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчинд зорчих иргэдийн аюулгүй байдлыг хангах, талбайд нэвтрэх боломжийг хязгаарлах зорилгоор барилгын ажлын талбайг нийтийн эзэмшлийн зам талбайгаас зориулалтын түр хашаагаар тусгаарласан байх;

3.1.3.Энэ журмын 3.1.2-д заасан хашаа нь “Барилгын талбайн түр хашаа”-ны стандартын шаардлага хангасан, хот, суурин газрын өнгө үзэмжид нийцсэн, хүн зорчих хэсэгт өндрөөс унах эд зүйлийн ачааллын үйлчлэлийг тэсвэрлэх, зориулалтын материалаар хийсэн хамгаалалтын үргэлжилсэн саравчтай байх;

3.1.4.Барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчин ажилтны ажиллах нөхцөлийг бүрэн хангахуйц нүд гялбахааргүй жигд гэрэлтүүлэгтэй, барилгын орц, гарц, хонгилыг ослын гэрэлтүүлгээр нэмж тоногловсон байх;

3.1.5.Шаардлагатай тохиолдолд барилгын ажлын талбай, гаднах орчинд дүрс бичлэгийн тоног төхөөрөмжийг байрлуулж хяналт тавих боломжийг бүрдүүлэх, аюул, ослын үед мэдээлэл өгөх, анхааруулах дохиолол суурилуулах;

3.1.6.Барилгын ажлын талбайн орц, гарцын дэргэд, барилгын хашааны гадна талын онцлох цэгүүдэд 1х2 метрээс багагүй хэмжээтэй “Барилгын мэдээллийн самбар”, “Барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг”-ыг нийтэд харагдахуйц байдлаар тус тус байрлуулах;

3.1.7.“Барилгын мэдээллийн самбар”-т баригдах барилгын талаарх мэдээлэл, барилгын захиалагч, ерөнхий гүйцэтгэгчийн нэр, хаяг, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтны нэр, холбоо барих утас, шаардлагатай зөвшөөрлийн талаарх мэдээлэл бичигдсэн байх;

3.1.8.“Барилгын талбайн зохион байгуулалтын зураг”-т барилгын байрлал, өргөх, тээвэрлэх машин механизмын зогсоол, өргөх байгууламжийн ажлын аюултай бүс, барилгад үйлчлэх зам талбай, барилгын ажлын талбай дахь түр байрууд (ажиллагсдын хувцас солих,

усанд орох байр, хооллох, бие засах газар, инженерийн түр сүлжээ ус, дулаан, цахилгааны гэх мэт) болон материал хураах талбайн байршил, автомашин, явган зорчигчийн орох, гарах гарц, ажлын байранд хүрэх замын чиглэл, гадна хашааг стандартын дагуу зурж үзүүлсэн байх;

3.1.9.Захиалагч, зураг төсөл зохиогч, гүйцэтгэгч хамтран барилгын ажлын талбайн гаднах эрсдэл бүхий орчны хил хязгаарыг барилгын ерөнхий өндөр, өргөх байгууламжийн үйлчлэлийн хүрээ, аюулгүйн бүс зэргийг үндэслэн тогтоож, зураглал үйлдэн баталгаажуулсан байх;

3.1.10.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах тэмдэг, тэмдэглэгээ, урьдчилан сэргийлэх дохио, санамж, анхааруулах зурагт хуудас, цугларах цэгийн тэмдгийг барилгын ажлын талбай, түүний гаднах эрсдэл бүхий орчинд байрлуулах;

3.1.11.Барилгын ажилд хэрэглэх цахилгаан хангамжийн түр сүлжээ, тоног төхөөрөмжийг аюулгүй ажиллагааны холбогдох дүрэм, журмын дагуу угсарч, суурилуулсан байх;

3.1.12.Барилгын ажлын талбайд байрлах ажилчдын түр байр нь эрүүл ахуйн шаардлага хангасан, аюултай бүсээс тусгаарлагдсан байх;

3.1.13.Барилгын ажлын талбайд материалын үйлдвэрлэл явуулах тохиолдолд тухайн хэсгийг хашаагаар тусгаарлан аюулгүй ажиллагааг хангасан байх;

3.1.14.Барилгын ажлын талбайд галын аюулаас урьдчилан сэргийлэх зориулалттай гал унтраах багаж, тоног төхөөрөмж бүхий галын сарай, тамхи татах цэгийг байгуулах;

3.1.15.Галын аюултай болон химийн хортой бодис, бүтээгдэхүүнийг барилгын ажлын талбайд хадгалах агуулахыг холбогдох хууль тогтоомж, барилгын норм дүрэм, стандартад нийцүүлэн тусгайлан бэлтгэх;

3.1.16.Барилгын ажлын талбайд гарч болзошгүй аюул, ослын үеийн аврах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах зохион байгуулалтын арга хэмжээг авсан байх;

3.1.17.Өргөх байгууламжийн үйлчлэлийн талбайд гудамж, зам талбай, байшин барилга болон барилгын ажлын талбай дахь түр байр орж байвал сумны эргэлт, өнгийлт, ачааны тэргэнцрийн шулуун явалтыг хязгаарлах, өргүүрийг камержуулах зэрэг техникийн арга хэмжээг урьдчилан авсан байх;

3.1.18.Захиалагч, гүйцэтгэгч нь талбайн инженер, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан болон шаардлагатай бусад ажилтныг барилгын ажлын талбайн хөдөлмөр зохион байгуулалт, аюулгүй ажиллагааны талаар мэдээлэх шуурхай удирдлага диспетчерийн холбооны хэрэгслээр бүрэн хангах;

3.1.19.Барилгын ажлын талбайд үзэгдэх орчин хязгаарлагдмал үед машин механизмд зориулалтын дуут дохионы төхөөрөмжийг суурилуулах;

3.1.20.Барилгын хог хаягдлыг орчны эрүүл ахуйд нөлөөлөхгүй байхаар зайлуулах арга хэмжээг холбогдох хууль тогтоомж, норм дүрмийн дагуу урьдчилан төлөвлөж, бэлтгэл ажлыг хангасан байх;

3.1.21.Барилгын үйлдвэрлэлийн ачаа тээвэрлэлт, ажилтнуудын тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг нэгдсэн зохицуулалт, хяналтанд оруулсан байх;

3.1.22.Барилгын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7-д заасны дагуу хөдөлмөр зохион байгуулалтын зураг боловсруулсан байх;

3.1.23.Барилгын ажлын талбайд хөрс бохирдуулагч нүхэн жорлон үүсгэхийг хориглох бөгөөд зөөврийн ариун цэврийн байгууламжийг ашиглана.

### **Дөрөв.Барилгын ажлын гүйцэтгэлийн шатанд тавих хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага**

4.1.Барилгын ажил гүйцэтгэхэд Барилгын тухай хуулийн 11.1.1-11.1.5-д заасан, барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчинд дараах зарчмыг баримталж ажиллагааг хийсэн байна:

4.1.1.Барилгын үе шатны ажилд эрсдэлийн үнэлгээ хийж, урьдчилан сэргийлэх арга хэмжээ бүрэн авсны дараа ажил эхлүүлэх;

4.1.2.Барилгын захиалагч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, зураг төсөл зохиогч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч нар нь хариуцан гүйцэтгэж байгаа ажлын нөхцөлд тохирсон хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн хангагдсан, хэрэглэж хэвшсэн байх;

4.1.3.Өргөн тээвэрлэх машин механизм, даралтат сав, шугам хоолой угсрах ажилд тусгай хөтөлбөрийн дагуу суралцаж, эрх авсан мэргэшсэн ажилтныг томилон ажиллуулах;

4.1.4.Өргөх байгууламжийг ашиглах барилгын ажил гүйцэтгэхдээ “Ачаа өргөх краныг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”, “Барилгын өргүүрийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”, “Сагстай өргөгчийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”, “Бетон зуурмагийн шахуургын аюулгүй ажиллагааны дүрэм”, “Лифтийг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”, “Эскалаторыг төхөөрөмжлөх, аюулгүй ашиглах дүрэм”-ийг тус тус мөрдөж ажиллах;

4.1.5.Тэсэрч дэлбэрэх, галын аюулгүй ажиллагааны тусгай шаардлага хангах, халуун нөхцөл, өндрийн болон хязгаарлагдмал орчинд ажиллах тохиолдолд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтнаас зөвшөөрөл авсан байх;

4.1.6.Энэ журмын 4.1.5-д заасан ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажил гүйцэтгэгч тухайн ажлыг удирдан зохион байгуулах ажилтныг томилсон байх;

4.1.7.Барилгын ажлын талбай, ажлын байранд барилгын материал, бүтээгдэхүүн, тоног төхөөрөмжийг Барилгын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу хадгалж, байрлуулах;

4.1.8.Барилгын өндрийн дагууд 2-3 давхар тутамд уналтаас хамгаалах 3.5м-ээс багагүй өргөнтэй хамгаалалтын төхөөрөмж (дэвсгэр, банз, тор, саравч) угсарч байрлуулах, гадна шатыг бат бэх тороор битүүлэх;

4.1.9.Аюул осол гарч болзошгүй орчны эрсдэлтэй бүсийг тогтоож, хаалт, хамгаалалтаар тусгаарлан, анхааруулах тэмдэг тавих;

4.2.Энэ журмын 4.1.9-д заасан хаалт, хамгаалалт, анхааруулах тэмдгийг дараах аюул, осол гарч болзошгүй орчинд байрлуулна:

4.2.1.цахилгаан шатны хонгил зэрэг ажилтан унах эрсдэлтэй газар;

4.2.2.тэсэлгээний ажил хийх газар;

4.2.3.барилгын ажилд ашиглаж байгаа өргөх механизм, цахилгаан шат байрлаж байгаа газар;

4.2.4.ажлын шат, хэв хашмалыг угсарч, буулгаж байгаа газар;

4.2.5.аюулгүйн хашлага угсарч, байрлуулах газар;

4.2.6.газрын хөрс нурж машин механизм, тоног төхөөрөмж унаж болзошгүй газар;

4.2.7.шороон болон хиймэл бүтээц, байгууламж нурж болзошгүй газар;

4.2.8.гал түймэр гарах, тэсэрч дэлбэрэх аюултай ажил гүйцэтгэх газар;

4.2.9.бутлах ажил гүйцэтгэх газар;

4.2.10.ажил гүйцэтгэх хязгаарлагдмал орчин;

4.2.11.эд зүйлс дээрээс унаж болзошгүй газар;

4.2.12.цахилгаан шугам сүлжээнд ойр, барилгын ажил гүйцэтгэх явцад цахилгаан гүйдэлд нэрвэгдэж болзошгүй газар;

4.2.13.өндөр даралтат усан шахуурга болон таслагч машинаар ажил гүйцэтгэх газар;

4.2.14.тусгай зориулалтын багаж хэрэгслээр тоног төхөөрөмж, бүтээцийн зэв арилгах явцад түүний үйлчлэлийн нөлөөлөлд бусад этгээд өртөж болох газар;

4.2.15.химийн болон шатах, тослох материалын хаягдал, үлдэц хадгалах газар;

4.2.16.шаардлагатай бусад газар.

4.3.Барилгын ажлын талбайд дараах баримт бичгийг байлгана:

4.3.1.ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээ;

4.3.2.ерөнхий болон туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж, байгууллагын барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн гэрчилгээ, архитектур төлөвлөлтийн даалгавар, загвар зураг, ерөнхий төлөвлөгөөний хуулбар;

4.3.3.барилгын ажлын захиалагч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, барилгын ажил гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч аж ахуйн нэгж байгууллагын хооронд байгуулсан гэрээ;

4.3.4.барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх зөвшөөрөл;

4.3.5.барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зураг;

4.3.6.барилгын ажлын талбайд дагаж мөрдөх хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн заавар;

4.3.7.инженер, техникийн ажилтан, мэргэжилтэй ажилчдын мэргэжлийн үнэмлэх;

4.3.8.гадаадын иргэд ажиллаж байгаа бол хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн үнэмлэх;

4.3.9.магадлал хийгдсэн иж бүрэн зураг төсөл;

4.3.10.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах арга хэмжээний төлөвлөгөө;

4.3.11.барилга угсралтын үе шатны ажил бүр дээр хийсэн эрсдэлийн үнэлгээ;

4.3.12.өргөх, зөөх, тээвэрлэх хэрэгсэлд засвар үйлчилгээ, тохируулгыг мэргэжлийн байгууллагаар хийлгэж, дүгнэлт гаргуулж баталгаажуулсан техникийн магадлагаа;

4.3.13.барилга угсралтын ажил гүйцэтгэсэн тэмдэглэл;

4.3.14.аюулгүй ажиллагааны зааварчилгааны дэвтэр;

4.3.15.ажилтнуудын цаг ашиглалтын бүртгэлийн дэвтэр.

4.4.Барилгын ажлыг түр болон удаан хугацаагаар зогсоох тохиолдолд барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг хангах арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

#### **Тав.Барилга байгууламжийг буулгахад тавигдах хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага**

5.1.Барилга байгууламжийг буулгахад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах арга хэмжээг ажил гүйцэтгэх төсөл, эрсдэлийн үнэлгээнд суурилсан аюулгүй ажиллагааны төлөвлөгөө, барилгын ажлын талбайн зохион байгуулалтын зурагт тус тус тодорхой тусгана.

5.1.1.Барилга байгууламжийн буулгалтын ажил гэж Барилгын тухай хуулийн 4.1.24-д заасан ажлыг хэлэх бөгөөд барилга

байгууламжийг буулгахдаа эрх бүхий байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авч гүйцэтгэнэ.

5.1.2.Барилгын тухай хуулийн 16.3-д заасны дагуу Барилга байгууламжийн буулгалтын ажлыг гүйцэтгэхдээ барилгын ажлын талбайн болон үйлдвэрлэлийн зохион байгуулалтын зураг боловсруулсан байна.

5.2.Барилга байгууламжийг буулгалтын ажил (цаашид буулгах ажил гэх)-ын явцад чичиргээ, доргилт, түүний нөлөөллөөс болж тоос, шороо, хий үнэр зэрэг бусад барилга, байгууламжид эвдрэл, гэмтэл учруулахгүй байх, орчны аюулгүй байдлыг хангахад чиглэгдсэн урьдчилан сэргийлэх арга хэмжээг авсан байна.

5.3.Буулгалтын ажил эхлэхээс 5-аас доошгүй өдрийн өмнө харьяалах барилга байгууламжийн техникийн улсын хяналт хэрэгжүүлэх байгууллагад албан ёсоор мэдэгдэнэ.

5.4.Барилгад асбест, галын болон тэсэрч, дэлбэрэх аюултай бодис, эд зүйл байгаа эсэхийг зохих мэргэжлийн байгууллагаар урьдчилан тогтоолгож дүгнэлт гаргуулна.

5.5.Буулгах ажлын үед барилгын ажлын талбайд гал унтраах хэрэгслийг бэлэн байлгаж, ажилтнуудад хэрхэн ашиглах талаар мэдлэг, чадвар эзэмшүүлсэн байна.

5.6.Хог хаягдлын бүсийг тогтоож, зориулалтын хаалт, хашлагаар хамгаалан овоолго үүсэхээс өмнө хог хаягдлын ачилт, тээвэрлэлтийн үйл ажиллагаа явуулдаг эрх бүхий иргэн, хуулийн этгээдэд шилжүүлж, үйлчилгээний хөлсийг бүрэн хариуцна.

5.6.1.Барилгын ажлын талбайгаас гарах шороог зөвшөөрөгдсөн хог хаягдлын цэгт зөөвөрлөж, хар шороог ногоон байгууламжийн ажилд ашиглана.

5.7.Керамзит, уурын зуухны үнс, элс, хайрга зэрэг нарийн ширхэглэлтэй материалын хаягдлыг бат бэх, дуу чимээ бага гаргадаг материалаар хийгдсэн хоолойгоор зөөвөрлөж буулгана.

5.8.Энэ журмын 5.7-д заасан хоолой нь барилга байгууламжид зохих журмын дагуу бэхлэгдсэн, хүн унахаас урьдчилан сэргийлсэн зориулалтын тагтай байна.

5.9.Гэнэтийн нуралтаас урьдчилан сэргийлж барилгын дээвэр, хана, хучилт, шалны төлөв байдалд “Барилга байгууламжийн буулгах үйл ажиллагааны дүрэм”-ийн дагуу гүйцэтгэнэ.

5.10.Буулгах ажлыг удирдан зохион байгуулах зөвлөх мэргэжилтнийг барилгын ажил гүйцэтгэгч томилон ажиллуулах бөгөөд уг ажилтны хяналтад буулгах ажлыг төлөвлөж, гүйцэтгэнэ.

5.11.Зөвлөх мэргэжилтэн нь буулгах ажлыг гүйцэтгэх мэргэшүүлэх сургалтад хамрагдсан, барилгын ажлын туршлагатай байна.

5.12.Буулгах барилга байгууламжийн цахилгаан эрчим хүчний болон бусад инженерийн шугам сүлжээний эх үүсвэр бүрэн салгасан эсэхийг захиалагч, гүйцэтгэгчтэй хамтран шалгаж, акт үйлдэнэ.

5.13.Буулгах ажил эхлэхийн өмнө шилэн хийц бүхий эд зүйл болон цонх, хаалганы шилийг бүрэн авсан байна.

5.14.Буулгаж дуусаагүй барилгын их биеийн хэсгийг шаардлагатай тоног төхөөрөмж, машин механизмын тусламжтайгаар бэхэлгээ, тулгуур, ивээс хийж, аюулгүй байдлыг бүрэн хангана.

5.15.Буулгах ажлыг зөвхөн өдрийн цагаар (байгалийн гэрэлтүүлэгтэй үед) гүйцэтгэнэ.

### **Зургаа.Барилгын ажилд оролцогчдын эрх, үүрэг**

6.1.Барилгын хөрөнгө оруулагч, захиалагч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч, ерөнхий болон туслан гүйцэтгэгч нь Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Барилгын тухай хуульд заасан эрх, үүргээс гадна дор дурдсан эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

6.2.Хөрөнгө оруулагч болон Захиалагчийн эрх, үүрэг:

6.2.1.энэ журмын 2.7-д заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах төлөвлөгөөний хэрэгжилтэд шаардагдах, санхүүжилтийг зарцуулахад хяналт тавих;

6.2.2.энэ журмын 2.8-д заасан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангахад зарцуулах хөрөнгийг бүрэн санхүүжүүлэх;

6.2.3.гүйцэтгэгч хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл ахуйн шаардлага хангахад зарцуулах хөрөнгийг зориулалтын бусаар ашигласан, зарцуулаагүй үлдээсэн тохиолдолд буцааж төлөхийг шаардах;

6.2.4.ерөнхий болон туслан гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үед тухайн хуулийн этгээд осол, зөрчил гаргаж байсан эсэх талаар холбогдох байгууллагаас мэдээлэл авах;

6.2.5.осол гарах нөхцөл бүрдсэн болон осол гарсан үед гүйцэтгэгчийн үйл ажиллагааг шууд зогсоож, зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, холбогдох байгууллагад хандах;

6.2.6.гүйцэтгэгч барилгын ажлын явцад хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллаагүйгээс осол, гэмтэл гарсан тохиолдолд санхүүжилтийг зогсоох хүртэл арга хэмжээ авах;

6.2.7.Хөрөнгө оруулагч болон Захиалагч нь энэхүү журмын шаардлага, хэрэгжилтийг хангуулж ажиллах;

6.2.8.барилгын үйл ажиллагаа эхлэхээс 5 хоногийн өмнө харьяалагдах хяналт шалгалтын байгууллагад мэдэгдэх;

6.2.9.Барилгын үйл ажиллагаа эхлэхээс өмнө холбогдох эрх бүхий байгууллагаас барилгын ажлын зөвшөөрлийг бүрэн авсан байх.

6.3. Гүйцэтгэгчийн эрх, үүрэг:

6.3.1. Холбогдох үе шатны зөвшөөрөл бүрэн аваагүй тохиолдолд барилгын гүйцэтгэл хийхгүй байх, ажил эхлэхийн өмнө барилгын ажлын талбайд ажиллах ажилтнуудын талаарх холбогдох мэдээллийг захиалагчид өгөх;

6.3.2. энэ журмын 6.3.1-д заасан мэдээллийг барилгын ажлын талбайд ажиллаж байгаа орон тооны болон туслан гүйцэтгэгчийн ажилтны тоог мэргэжлийн ангиллаар нь нарийвчлан долоо хоног бүр гаргаж байх;

6.3.3. барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах арга хэмжээнд зарцуулах зардлыг зориулалтаар нь ашиглах, зарцуулалтын тайланг барилгын үе шатны ажлын санхүүжилт авахын өмнө захиалагчид албан ёсоор гаргаж өгөх, тайлангийн хувийг барилгын ажлын талбайд байнга хадгалах;

6.3.4. захиалагч болон хяналтын байгууллагын ажилтан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг хангах арга хэмжээний зардлын зарцуулалтын тайланг хянах нөхцөлөөр хангах;

6.3.5. аюулгүй ажиллагааг хангах төлөвлөгөө, эрсдэлийн үнэлгээг үндэслэн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж ажиллах;

6.3.6. салхивч, шугам хоолой, шат, цахилгаан шатны хонгилыг хамгаалж, аюул, осол гарахаас урьдчилан сэргийлэх, барилгын гадна талын хамгаалалтыг хийж, барилгын ажлын талбайн гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдлыг бүрэн хангасан байх;

6.3.7. барилга байгууламжийн төвөгшлийн зэргээс хамаарч барилгын ажлын талбайд эмнэлгийн анхны тусламж үзүүлэх ажилтан (эмч, бага эмч, сувилагч) ажиллуулж, байршил болон холбогдох мэдээллийг нүдэнд харагдахуйц газар байрлуулах бөгөөд шаардлага хангасан эмийн сан, багаж хэрэгслээр хангах;

6.3.8. эмнэлгийн тусламж дуудах утасны дугаарыг нүдэнд ил харагдах газар байрлуулах, анхны тусламж авсан ажилтны талаар өдөр тутам тэмдэглэл хөтөлж байх;

6.3.9. барилгын ажлын талбайд ажилтанд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн мэдээлэл өгөх, мэдлэг дэдлага олгох сургалт зохион байгуулах өрөө, танхим, булантай байх;

6.3.10. ажилтныг ажилд авахын өмнө эрүүл мэндийн багц үзлэг, шинжилгээнд хамруулан, эрүүл мэндийн байдалд дүгнэлт гаргуулж, ажилтны хувийн хэрэгт хадгалах;

6.3.11. өндөр эрсдэлтэй ажлыг гүйцэтгэх ажилтныг ажил үүргийн онцлогт нь тохирсон нэмэлт хувцас, хамгаалах хэрэгслээр бүрэн

хангах;

6.3.12.гадаад улсын ажилтан ажиллаж байгаа тохиолдолд шаардлагатай мэдээлэл, зааварчилгаа, сургалтыг эх хэлээр нь өгсөн байх;

6.3.13.барилгын ажлын талбайд зөвхөн зориулалтын өргөх төхөөрөмжөөр ажилтныг тээвэрлэх;

6.3.14.ажил гүйцэтгэх орчин нь ажилтнуудын аюулгүй байдлыг хангасан тоноглолтой байх;

6.3.15.барилгын ажлын талбайд ашиглагдаж байгаа цахилгаан байгууламж, тоног төхөөрөмжийн хаалгыг байнга цоож, түгжээтэй, хамгаалалттай байлгах;

6.3.16.цахилгаан үүсвэртэй машин механизмын газардуулгыг хийж, баталгаажуулсан байх;

6.3.17.газарт хийх боломжтой ажлыг өндөрт хийхгүй байх;

6.3.18.туслан гүйцэтгэгчид хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, зааврын талаар мэдээлэл өгч түүний хэрэгжилтэд хяналт тавих;

6.3.19.ажил хаялт зарласан, ажил зогссон, ажил удаан хугацаанд саатсан бол захиалагчид нэн даруй мэдээллэх;

6.3.20.барилгын ажил эхлэхээс өмнө энэ журмын 2.7, 3.1.17-д заасан төлөвлөгөөг харьяалах хяналтын байгууллагад хүргүүлэх;

6.3.21.Гүйцэтгэгч нь энэхүү журмын шаардлага, хэрэгжилтийг хангаж ажиллана.

6.4.Туслан гүйцэтгэгчийн эрх, үүрэг:

6.4.1.энэ журмын 6.3.10, 6.3.11, 6.3.12, 6.3.13, 6.3.17-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллаж;

6.4.2.ерөнхий гүйцэтгэгчийн тавьсан хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйтай холбоотой хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

6.4.3.ажил гүйцэтгэх гэрээнд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг тодорхой тусгах;

6.4.4.барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны хаалт, хамгаалалт, дохиолол, зурагт хуудсыг эвдэж гэмтээхүй байх, тэмдэг тэмдэглэгээ, схем зураг, санамжийг дагаж мөрдөх;

6.4.5.ажил үүрэгтээ хамааралгүй бүсэд нэвтрэхгүй байх.

6.5.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн баг, ажилтны эрх үүрэг:

6.5.1.ажлын байрны эрсдлийн үнэлгээ болон шинэ техник, технологи, материал хэрэглэснээс шалтгаалан ажлын байрны нөхцөлд гарсан өөрчлөлтийг тусган ажлын байрны аюулгүй ажиллагааны зааврыг шинээр буюу шинэчлэн боловсруулж батлуулах;

6.5.2.эрсдэлийн үнэлгээний дагуу хөдөлмөрийн аюулгүй байдал,

эрүүл ахуйн сургалтын хөтөлбөр, агуулгыг шинэчлэн, ажилтнуудад тухай бүрт мэдээлэл өгч сургалт зохион байгуулах;

6.5.3.ажилтнуудыг иж бүрэн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцсаар хангуулах, хэрэглээнд хяналт тавих;

6.5.4.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуульд заасны дагуу гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах талаар барилгын ажилд оролцогчдод шаардлага тавьж биелэлтийг хангуулах;

6.5.5.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангаагүй тоног төхөөрөмж, нэгжийн үйл ажиллагааг зөрчил арилгах хүртэл хугацаагаар зогсоох;

6.5.6.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн ажилтанд арга хэмжээ авах талаар эрх бүхий этгээдэд санал тавьж шийдвэрлүүлэх;

6.5.7.энэ журмын 4.1.5-д заасан ажлыг гүйцэтгэхэд зөвшөөрөл олгох, энэ журмын 4.1.6-д заасан удирдан зохион байгуулах ажилтныг томилуулах;

6.5.8.барилгын ажлын талбайд хог хаягдлын бөөгнөрөл бий болгохгүй байх арга хэмжээ авах, тогтмол хяналт тавих, барилгын талбайд үүссэн хог хаягдлыг цуглуулан, тухай бүр хог тээврийн гэрээ бүхий байгууллага болон өөрсдийн зориулалтын тээврийн хэрэгслээр нэгдсэн хог хаягдлын цэгт тээвэрлэн зайлуулах;

6.5.9.осол гарах нөхцөл бүрдсэн болон гарсан тохиолдолд шалтгаан нөхцөлийг ажлын байр бүрээр судлан бүртгэж, мэдээлэл, аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;

6.5.10.барилгын ажлын талбайд зайлшгүй шаардлагаар гадны хүн, зочид, төлөөлөгчид нэвтрэх тохиолдолд хувийн хамгаалах хэрэгслээр хангаж, аюулгүй ажиллагааны зааварчилгаа өгч, гарын үсэг зуруулж баталгаажуулсан байх;

6.5.11.Гэр хорооллын дахин төлөвлөлт болон хөрсний бохирдол ихтэй газар барилга байгууламж барихын өмнө хатуу шингэн хог хаягдлыг цэвэрлэн зайлуулсны дараа мэргэжлийн байгууллагаар халдваргүйтгэл хийлгэх;

6.5.12.Барилга угсралтын явцад хөрс, орчны бохирдуулахгүй нүхэн жорлон, бохир усны цооног, Техникийн шаардлага MNS 5924:2015 стандартын шаардлага хангасан түр бие засах газар болон гар угаах нөхцөлөөр хангах арга хэмжээ авах.

6.6.Барилгын ажил гүйцэтгэж байгаа ажилтны эрх, үүрэг:

6.6.1.барилгын ажил эхлэхээс өмнө тухайн барилгын ажлын талбайн хөдөлмөрийн аюул байдал, эрүүл ахуйн талаар зохион

байгуулсан сургалт, зааварчилгаанд хамрагдсан байх;

6.6.2.сургалт, зааварчилгаанд хамрагдаагүй тохиолдолд ажил гүйцэтгэхээс татгалзах;

6.6.3.барилгын ажил гүйцэтгэхэд мөрдөгдөж байгаа дүрэм, журам, зааврын зөв эсэхэд эргэлзэж байвал хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан болон тухайн ажлыг удирдаж байгаа эрх бүхий ажилтнаас тодруулга авах;

6.6.4.ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангахыг шаардах;

6.6.5.ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг ажлын байранд тогтмол, бүрэн хэрэглэж хэвшсэн байх;

6.6.6.ажиллах болон амрах эрүүл, аюулгүй орчин нөхцөлөөр хангахыг шаардах;

6.6.7.орчны эмх цэгц, эрүүл ахуйн шаардлагыг хангах, тухайн ажил дууссаны дараа болон ажлын байраа солихын өмнө байрны эмх цэгцийг хангаж цэвэрлэсэн байх;

6.6.8.машин механизм, тоног төхөөрөмж, аппарат, багаж хэрэгслийг зөвшөөрөлгүй хөдөлгөх, зориулалтын бусаар ашиглах, байршлыг өөрчлөхгүй байх;

6.6.9.ажил үүргээ гүйцэтгэх явцад аюулгүй ажиллагааны нөхцөл зөрчигдөж хүний амь нас, эрүүл мэндэд сөрөг, аюултай нөхцөл байдал бий болсон тохиолдолд ажлаа шууд зогсоож, энэ тухай эрх бүхий ажилтанд нэн даруй мэдэгдэх, үүссэн нөхцөл байдалд тохирсон арга хэмжээг хэрэгжүүлэх;

6.6.10.бусад ажилтнуудын аюулгүй байдлыг хангаж, ажил үүргээ анхаарал болгоомжтой, зөв гүйцэтгэх, эмнэлгийн анхны тусламж үзүүлэх арга барилд суралцсан байх;

6.6.11.эмнэлгийн ээлжит үзлэгээс гадна шаардлагатай тохиолдолд эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж, эрүүл мэндээ хамгаалах;

6.6.12.зөвхөн зориулалтын газар хооллох;

6.6.13.энэ журмын 4.1.5-д заасан ажлыг зөвшөөрөл авч гүйцэтгэх;

6.6.14.ажил үүрэгт хамааралгүй бүс, ажлын байранд эрх бүхий ажилтны зөвшөөрснөөс бусад тохиолдолд нэвтрэхгүй байх;

6.6.15.хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн арга хэмжээг хэрэгжүүлэхэд эрх бүхий ажилтантай хамтарч ажиллах;

6.6.16.барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчинд тавигдсан аюул, осол, гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмдэг, тэмдэглэгээг дагаж мөрдөх.

6.7.Зөвлөх үйлчилгээ үзүүлэгчийн эрх, үүрэг:

6.7.1.Зураг төсөл зохиогч барилгын үе шатны ажилбар бүрд

зохиогчийн хяналтыг хэрэгжүүлэхдээ Барилгын тухай хуулийн 12.1.7-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж, зөвлөн туслах үйлчилгээг үзүүлэх;

6.7.2.захиалагч, гүйцэтгэгчтэй гэрээ байгуулж хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн асуудлыг хариуцан ажиллаж байгаа тохиолдолд энэ журмын 6.2, 6.5-д заасан эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах;

6.7.3.Барилгын тухай хуулийн 42 дүгээр зүйлийн 42.1.6 дахь заалтад заасан дүгнэлтийг гаргана.

### **Долоо.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага, хяналт**

7.1.Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангахад тавих хяналт, шалгалт (цаашид “хяналт” гэх) нь барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчны аюулгүй байдал, эрүүл ахуйг хангахад чиглэгдэнэ.

7.2.Гүйцэтгэгч барилгын ажилд тавих хяналтыг дараах үе шатаар зохион байгуулна.

7.2.1.анхан шатны хяналтыг тухайн ажлыг удирдан гүйцэтгэж буй талбайн инженер, хэсгийн инженер, бригадын дарга өдөр бүр ажил эхлэхийн өмнө болон ажлын гүйцэтгэлийн явцад гүйцэтгэнэ. Хяналтаар илэрсэн зөрчил дутагдлыг анхан шатны хяналтын дэвтэрт тэмдэглэж , тэдгээр зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг нэн даруй төлөвлөж, гүйцэтгэлийн тайланг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтанд мэдээлж байх;

7.2.2.хоёрдугаар шатны хяналтыг сард 2 удаа хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн баг, ажилтан гүйцэтгэж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах;

7.2.3.гуравдугаар шатны хяналтыг эрх бүхий этгээдээс томилсон комисс улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулна. Дүнг тухайн комиссын ахлагч, эрх бүхий ажилтнуудыг оролцуулан хэлэлцэж, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм, журмыг зөрчсөн ажилтанд хариуцлага тооцож, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээг авч, хэрэгжилтэд хяналт тавих;

7.3.энэ журмын 7.2-т заасан хяналтыг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг гүйцэтгэгч баталсан байна.

7.4.Гүйцэтгэгчийн дотоод хяналтын нэгж нь хяналт тавих үйл ажиллагаандаа байгууллагын дотоод хяналтыг зохион байгуулах дүрэм, журамд заасан чиг үүргээс гадна барилгын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангах чиглэлээр энэ журмын 6.3, 6.4, 6.5, 6.6, 7.2-т заасан үүргийн биелэлтэд хяналт тавина.

7.5.Гүйцэтгэгч дотоод хяналтаас гадна төрийн ба төрийн бус байгууллага, хамтран ажилладаг бусад мэргэжлийн байгууллагын

хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн эрх бүхий ажилтнуудаар хөндлөнгийн хяналт хийлгэж болно. Хөндлөнгийн хяналтын бүрэлдэхүүн, зорилго, үр дүнгийн талаар захиалагчид мэдэгдсэн байна.

7.6.Захиалагч болон зөвлөх үйлчилгээ үзүүлэгч энэ журмын 7.2, 7.4-т заасан хяналтыг гүйцэтгэгч хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавина.

7.7.Холбогдох чиг үүрэг бүхий улсын байцаагч нь хууль тогтоомжид заасан болон барилгын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

7.7.1.энэ журмын 2.7, 3.1.17-д заасан эрсдэлийн үнэлгээ, аврах ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн төлөвлөгөөт хяналт хийж, эрсдэлийг бууруулах, гарч болзошгүй аюул ослоос урьдчилан сэргийлэх талаар албан шаардлага, зөвлөмж хүргүүлж, биелэлтийг хангуулах;

7.7.2.барилгын ажлын талбай түүний гаднах эрсдэл бүхий орчинд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангагдаагүй талаар барилгын ажилд оролцогчид, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, хүсэлт, мэдээлэл болон барилгад аюул, осол гарсан үед төлөвлөгөөт бус хяналтыг хийж илэрсэн зөрчил, учирсан хохирлыг арилгуулах арга хэмжээ авах;

7.7.3.захиалагч, гүйцэтгэгч, зөвлөх үйлчилгээ үзүүлэгч нь барилгын ажилд хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн чиглэлээр энэ журмын 7.2, 7.3, 7.6-д заасан хяналтыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавьж, үнэлэлт дүгнэлт өгөх, илэрсэн зөрчлийг арилгуулахаар хуульд заасан арга хэмжээ авах;

7.7.4.энэ журмын 7.7.1, 7.7.2, 7.7.3-д заасан хяналтыг батлагдсан хяналтын хуудас ашиглан гүйцэтгэх.

### **Найм.Бусад**

8.1.Барилгын ажил гүйцэтгэж байгаа ажилтан энэ журамд тусгагдсаны дагуу сургалт, зааварчилгаанд хамрагдаагүй тохиолдолд ажил гүйцэтгэхээс татгалзах, ажлын хувцас, хамгаалах хэрэгслээр хангахыг шаардах, ажиллах болон амрах эрүүл, аюулгүй орчин нөхцөлөөр хангахыг шаардах зэрэг шаардлагыг тавьсан нь хариуцлага хүлээлгэх, хөдөлмөрийн гэрээг цуцлах үндэслэл болохгүй.

### **Ес.Хариуцлага**

9.1.Энэ журмыг зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

**БУЛГАН АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТОГТООЛ**

2026 оны 3 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 08/07

Гурванбулаг  
сум

**СУУРИН МАЛ МАЛЛАГААНЫ БҮС ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.13 дах заалт, 35 дугаар зүйлийн 35.1.14, 35.1.17, Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, Газрын тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.4, 52.6 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.Сумын төвийн суурин мал маллагааны бүсийг Хулст багийн Хаяа дэрсэд байхаар тогтоосугай.

2.Сумын төвийн суурин мал маллагааны байршлын зураг, газрын хэмжээг 1 дүгээр хавсралтаар, суурин мал маллагааны бүсэд мөрдөгдөх журмыг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3.Тогтоолыг хэрэгжүүлэх талаар удирдлага зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллан, үр дүнг тооцон, хэрэгжилтийн тайланг иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд жил бүр танилцуулж байхыг Засаг дарга (Б.Дэлгэр)-д үүрэг болгосугай.

4.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Нутгийн удирдлага, ёс зүйн асуудал хариуцсан хороо, Хүнс хөдөө аж ахуй, байгаль орчны асуудал хариуцсан хороонд тус тус даалгасугай.

ДАРГА

А.ЭРДЭНЭБУЛГАН

Гурванбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
хуралдааны 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн  
08/07 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## БУЛГАН АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН ТӨВИЙН СУУРИН МАЛ МАЛЛАГААНЫ БҮСИЙН БАЙРШЛЫН ЗУРАГ



Сумын төвийн суурин мал маллагааны бүсийн эргэлтийн цэгийн  
дугаар, солбицол

Цэгийн дугаар	N	E
<b>Хаяа дэрс</b>		
1	47°45'4.65"N	103°30'21.89"E
2	47°45'17.86"N	103°30'47.34"E
3	47°44'58.55"N	103°30'28.61"E
4	47°45'10.64"N	103°30'55.29"E

*Гурванбулаг сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
хуралдааны 2026 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн  
08/07 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт*

## **БУЛГАН АЙМГИЙН ГУРВАНБУЛАГ СУМЫН СУУРИН МАЛ МАЛЛАГААНЫ БҮСЭД МӨРДӨГДӨХ ЖУРАМ**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Зорилго: Сумын төвд мал бэлчсэнээр нийтийн эзэмшлийн зам талбайг их хэмжээгээр бохирдуулах, ногоон байгууламжийг сүйтгэж, хайс эвдэх, байшин хорооллын оршин суугчдын хогийг тараах, малын гоц халдварт өвчин гарч хорио цээрийн дэглэм тогтоож байсан зэргээр сөрөг үр дагаврууд ихээр гарч иргэдийн цэвэр аюулгүй орчинд амьдрах эрх зөрчигдөж байгаатай холбогдуулан иргэд оршин суугчдын дунд явуулсан санал асуулга, хэлэлцүүлгээс гарсан саналыг үндэслэн малтай өрхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас тогтоосон суурин мал маллагааны бүс нутагт нүүлгэн шилжүүлэхэд оршино.

1.2.Журмын хэрэгжилтийг сумын Засаг дарга удирдлага зохион байгуулалтаар хангаж, Засаг даргын Тамгын газар, Газрын даамал, Байгаль орчны хяналтын улсын байцаагч, Хөдөө аж ахуйн тасаг, Мал эмнэлгийн тасаг, Багийн Засаг дарга нар, иргэд, малчид хариуцан гүйцэтгэнэ.

### **Хоёр.Засаг даргын Тамгын газрын хүлээх үүрэг**

2.1.Нэг малчин болон мал бүхий өрхөд ногдох газрын хэмжээг 1200 м2 хүртэл байхаар тогтоож, газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж газар эзэмшүүлэх, гэрчилгээжүүлэх ажлыг зохион байгуулах.

2.2.Бэлчээрийг усжуулах, хүн малын ундны усан хангамжийг сайжруулах талаар дэмжих.

2.3.Малын үүлдэр угсаа чанарыг сайжруулах, эрчимжсэн мал аж ахуйг эрхлэх талаар дэмжиж, төсөл хөтөлбөрт хамруулах.

2.4.Тэжээлийн ургамал тарих сургалтад хамруулж, тэжээлийн ургамал тарих, дарш хийж сурахад дэмжлэг үзүүлэх.

2.5.Суурин мал маллагааны бүсэд мал маллахыг цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээ мэдээллийг хүргэх.

2.6.Мал оруулахыг хориглосон болон ногоон бүсийн тэмдэг тэмдэглэгээг бүс болгон дээр байршуулах.

### **Гурав.Сумын суурин мал маллагааны бүсэд суурьших малчин өрхийн хүлээх үүрэг**

3.1.Тогтоосон хугацаанд, заасан газарт малын хашаа хороог барьж тохижуулж суурьших.

3.2.Сумын төвийн ногоон бүсийн болон мал оруулахыг хориглосон

тэмдэг тэмдэглэгээнээс дотогш малаа бэлчээхгүй байх.

3.3.Малын халдварт болон паразит өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд мал, амьтныг цаг тухайд нь бүрэн хамруулах.

3.4.Малын өтөг бууцыг иргэн өөрийн тээврийн хэрэгслээр төвлөрсөн хогийн цэгт тээвэрлэж зөөж хаях.

3.5.Суурин мал маллагааны бүсийн гудамж хорооллыг цэвэр байлгах, малын гаралтай аргал, өтөг бууцыг нийтийн эзэмшлийн гудамж талбайд асгаж дэлгэхгүй байх.

3.6.Нүүлгэн шилжүүлэхтэй холбоотой төрийн байгууллагаас гарсан шийдвэрийг биелүүлэх.

3.7.Сумын төвийн ундны усны 3 худагт мал услахгүй байх, ойролцоо мал бэлчээхгүй байх.

3.8.Суурин мал маллагааны бүсэд мал бэлчээхгүй байх

3.9.Малаа бэлчээх тохиолдолд малын эзэн өөрийн биеэр хариулгатайгаар суурин мал маллагааны бүс, ногоон бүсээс гаргаж, бэлчээрийн бүсэд бэлчээх

3.10.12 дугаар сарын 01-ээс 03 дугаар сарын 15 хүртлэх хугацаанд ногоон бүс дотор айл өрхүүд өөрийн эзэмшил, өмчлөлийн хашаандаа тэжээх зориулалтаар мал оруулж ирж болно.

#### **Дөрөв. Журмыг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага**

Монгол Улсын хууль тогтоомж болон Иргэний хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу холбогдох арга хэмжээг авна.

Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд  
2026 оны 5 дугаар сарын 29-ний өдрийн 7604 дүгээрт бүртгээл

**ДОРНОГОВЬ АЙМАГ**  
**САЙНШАНД СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН**  
**ТОГТООЛ**

2026 оны 4 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 05

Сайншанд  
сум

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ**  
**ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 35.1.14 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь заалт, Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2 дахь заалт, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын хамтарсан 2018 оны 192, А/243 дугаар тушаалыг тус тус үндэслэн сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сайншанд сумын нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх зардлын нэгж тарифыг 1 дүгээр, энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг 2 дугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталсугай.

2. Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг батлагдсан тарифын дагуу иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудад дагаж мөрдүүлж ажиллахыг сумын Засаг дарга (Ч.Түвшинтөр)-д үүрэг болгосугай.

3. Тус тогтоолыг улсын нэгдсэн санд бүртгэсний дараа хүчин төгөлдөр дагаж мөрдүүлэхийг сумын Засаг дарга (Ч.Түвшинтөр)-д даалгасугай.

4. Захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд бүртгэгдэн хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн 07/05 дугаар тогтоол, 2022 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 09/06 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

М.БУЯНДЭЛГЭР

*Сайншанд сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн  
05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт*

**САЙНШАНД СУМЫН ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ  
ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ ЗАРДЛЫН НЭГЖ ТАРИФ**

1.Гэр хороолол

№	Үзүүлэлтүүд		Нэгж	Тоо хэмжээ
1	A	Нэг рейсийн тээвэрлэлтийн дундаж зай	км	20
2	B	Хөдөлгөөний үеийн шатахууны зарцуулалтын норм	Км/л	18
3	C	Нэг рейсд хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын дундаж	Км/л	3.6
4	D	Ачилтын үеийн шатахуун зарцуулалтын норм	Мин/л	0.02
5	E	Ачилтын үеийн цаг ашиглалт	мин	110
6	F	Ачилтын үеийн шатахуун зарцуулалт	Мин/л	2
7	G	Шатахууны үнэ	төг/л	3,770
<b>8</b>	<b>H</b>	<b>Нэг рейст зарцуулах шатахуун</b>	<b>төг/л</b>	<b>21,866</b>
9	I	Ажиллах хугацааны үндсэн цалин	төг/рейс	17,255
10	J	Ажилтны багаж хэрэгсэл	төг/рейс	4,749
<b>11</b>	<b>K</b>	<b>Нэг рейст шаардагдах зардал</b>	<b>төг/рейс</b>	<b>62,353</b>
12	L	Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардал	төг/рейс	16,098
13	M	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал	төг/рейс	2,385
14	N	Нэг рейст ачиг тээвэрлэх хогийн дундаж хэмжээ	төг/тн	5
<b>15</b>	<b>O</b>	<b>Нэг тонн хогийг тээвэрлэх зардал</b>	<b>тн/төг</b>	<b>13,856</b>

2.Орон сууц

№	Үзүүлэлтүүд		Нэгж	Тоо хэмжээ
1	A	Нэг рейсийн тээвэрлэлтийн дундаж зай	км	8
2	B	Хөдөлгөөний үеийн шатахууны зарцуулалтын норм	Км/л	18
3	C	Нэг рейсд хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын дундаж	Км/л	1.4
4	D	Ачилтын үеийн шатахуун зарцуулалтын норм	Мин/л	0.015
5	E	Ачилтын үеийн цаг ашиглалт	мин	20
6	F	Ачилтын үеийн шатахуун зарцуулалт	Мин/л	0.3
7	G	Шатахууны үнэ	төг/л	3,770
<b>8</b>	<b>H</b>	<b>Нэг рейст зарцуулах шатахуун</b>	<b>төг/л</b>	<b>6,560</b>
9	I	Ажиллах хугацааны үндсэн цалин	төг/рейс	11,628

10	J	Ажилтны багаж хэрэгсэл	төг/рейс	4,749
<b>11</b>	<b>K</b>	<b>Нэг рейст шаардагдах зардал</b>	<b>төг/рейс</b>	<b>24,534</b>
12	L	Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардал	төг/рейс	596
13	M	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал	төг/рейс	1,001
14	N	Нэг рейст ачиж тээвэрлэх хогийн дундаж хэмжээ	тн	5
<b>15</b>	<b>O</b>	<b>Нэг тонн хогийг тээвэрлэх зардал</b>	<b>тн/төг</b>	<b>5,452</b>

### 3.Аж ахуйн нэгж, байгууллага

№	Үзүүлэлтүүд		Нэгж	Тоо хэмжээ
1	A	Нэг рейсийн тээвэрлэлтийн дундаж зай	км	15
2	B	Хөдөлгөөний үеийн шатахууны зарцуулалтын норм	Км/л	25
3	C	Нэг рейсд хөдөлгөөний үеийн шатахуун зарцуулалтын дундаж	Км/л	3.8
4	D	Ачилтын үеийн шатахуун зарцуулалтын норм	Мин/л	0.02
5	E	Ачилтын үеийн цаг ашиглалт	мин	150
6	F	Ачилтын үеийн шатахуун зарцуулалт	Мин/л	3
7	G	Шатахууны үнэ	төг/л	3,770
<b>8</b>	<b>H</b>	<b>Нэг рейст зарцуулах шатахуун</b>	<b>төг/л</b>	<b>25,448</b>
9	I	Ажиллах хугацааны үндсэн цалин	төг/рейс	16,716
10	J	Ажилтны багаж хэрэгсэл	төг/рейс	4,749
<b>11</b>	<b>K</b>	<b>Нэг рейст шаардагдах зардал</b>	<b>төг/рейс</b>	<b>63,663</b>
12	L	Тээврийн хэрэгслийн элэгдлийн зардал	төг/рейс	15,595
13	M	Тээврийн хэрэгслийн засвар үйлчилгээний зардал	төг/рейс	1,155
14	N	Нэг рейст ачиж тээвэрлэх хогийн дундаж хэмжээ	тн	4
<b>15</b>	<b>O</b>	<b>Нэг тонн хогийг тээвэрлэх зардал</b>	<b>тн/төг</b>	<b>15,916</b>

**Сайншанд сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2026 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн  
05 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт**

**ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХУРААМЖИЙН ХЭМЖЭЭ**

№	Хог хаягдлын нормативын ангилал	Хэмжих нэгж /сараар/	Хураамжийн хэмжээ /төгрөг/
1	Хувийн байр, гэр хорооллын айл өрх	өрх/төг	4500
2	Нийтийн орон сууцны айл өрх	өрх/төг	4500
3	Хот суурин газрын мал бүхий айл өрх	өрх/төг	45000
4	Авто бааз, авто засварын газар	сар/төг	75000
5	Жижиглэн худалдаа /Мухлаг болон түүнтэй дүйцэхүйц жижиг худалдаа 20м <sup>2</sup> хүртэлх/	сар/төг	4500
6	Зах, худалдаа, бөөний төв	сар/төг	150000
7	Дэлгүүр /тусгай зөвшөөрлийн аж ахуйн нэгж/	сар/төг	30000
8	Хүнс барааны дэлгүүр	сар/төг	15000
9	Барилгын материалын дэлгүүр	сар/төг	75000
10	Үсчин, гутал засварчин, зурагчин, гар утасны засвар, дугуй засвар, авто угаалга, бусад	сар/төг	10000
11	Цайны газар, гуанз, хоолны газар, кафе	сар/төг	15000
12	Ресторан, бар, караоке	сар/төг	75000
13	Зочид будал	20 хүртэлх ортой сар/төг	30000
		21 дээш ортой сар/төг	75000
14	Сувиллын газар	20 хүртэлх ортой сар/төг	30000
		21 дээш ортой сар/төг	40000
15	Сургууль	дотуур байргүй сар/төг	30000
		дотуур байртай сар/төг	45000
16	Цэцэрлэг	сар/төг	10000
17	Эмийн сан	сар/төг	45000
18	Эмнэлэг	Нэгдсэн эмнэлэг сар/төг	75000
		Өрхийн эмнэлэг сар/төг	15000
		25 хүртэлх ортой сар/төг	30000

19	Сургууль, цэцэрлэгээс бусад төсөвт байгууллага, аж ахуйн нэгж		5 хүртэлх хүнтэй сар/төг	9000
			6-20 хүртэлх хүнтэй сар/төг	18000
			20-оос дээш хүнтэй сар/төг	30000
20	Шатахуун түгээх станц		сар/төг	120000
21	Интернет кафе		сар/төг	15000
22	Үйлдвэрийн газар	хүнд	сар/төг	225000
		хөнгөн	сар/төг	75000
23	Жижиг дунд үйлдвэр		сар/төг	30000
24	Уул уурхай олборлолт, хайгуулын үйл ажиллагаа явуулж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас гарах ахуйн хог хаягдал		сар/төг	900000
25	Нефть олборлох, боловсруулах үйлдвэр		сар/төг	900000
26	Нефть хадгалах агуулах		сар/төг	375000
27	Ачилт буулгалтын талбай		сар/төг	375000
28	Фермерийн аж ахуй		сар/төг	45000
29	Хүнс барааны агуулах		сар/төг	60000

## БОЛОВСРОЛЫН САЙДЫН ТУШААЛ

2026 оны 4 дүгээр  
сарын 22-ны өдөр

Дугаар А/17

Улаанбаатар  
хот

### ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Боловсролын ерөнхий хуулийн 26 дугаар зүйлийн 26.1.24 дэх заалт, Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.6 дахь заалт, Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор батлагдсан “Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам”-ын 1.4.1-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмын хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллахыг Боловсролын ерөнхий газар /Г.Ням-Очир/-т, орон нутгийн боловсролын сургалтын байгууллагыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангаж, хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн боловсролын газарт, хэрэгжилтийг хангаж ажиллахыг ерөнхий боловсролын сургуулийн захирал нарт тус тус даалгасугай.

3.Журмын хэрэгжилтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, үр дүнг танилцуулж ажиллахыг Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар (Л.Төгсбаяр)-т үүрэг болгосугай.

4.Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Боловсролын сайдын 2026 оны “Журам батлах тухай” А/21 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Л.ЭНХ-АМГАЛАН

*Боловсролын сайдын 2026 оны 4 дүгээр сарын 22-ны  
өдрийн А/17 дугаар тушаалын хавсралт*

**СУРГУУЛИЙН ХООЛ, ҮЙЛДВЭРЛЭЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ДОТООД  
ХЯНАЛТЫН ЖУРАМ**

**Нэг.Ерөнхий зүйл**

1.1.Энэхүү журмаар өмчийн бүх хэлбэрийн ерөнхий боловсролын сургууль, дотуур байрны /цаашид “сургууль” гэх/ хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд дотоод хяналтыг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулна.

1.2.Дотоод хяналтын зорилго нь сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний технологийн шат дамжлага бүрт үйлдвэрлэлийн болон эрүүл ахуйн зохистой дадлыг өдөр тутмын үйл ажиллагаанд хэвшүүлэх замаар шим тэжээлийн тэнцвэртэй, баталгаатай хоол, хүнсээр тэгш, хүртээмжтэй үйлчлэх, хоол хүнсний хордлогот халдвараас урьдчилан сэргийлэхэд чиглэгдэнэ.

1.3.Дотоод хяналтын үйл ажиллагаа нь хууль тогтоомжид нийцсэн, ил тод, нээлттэй, шударга, үнэн зөв, бодитой, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байна.

1.4.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих дотоод хяналтыг сургуулийн захирал, дотоод хяналтын нэгж/баг, холбогдох ажилтан (хоол зүйч, эмч, тогооч, бэлтгэгч зэрэг), хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд оролцон ажиллаж буй бусад ажилтнууд хэрэгжүүлнэ.

**Хоёр.Дотоод хяналтын хамрах хүрээ, зохион байгуулалт**

2.1.Дотоод хяналтад сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын зохион байгуулалт, тоног төхөөрөмж, багаж, хэрэгсэл, сав, баглаа боодол, инженерийн шугам сүлжээ, ажлын байрны эрүүл ахуйн нөхцөл болон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг захиалах, худалдан авах, тээвэрлэх, хүлээн авах, хадгалах, бэлтгэх, дулааны боловсруулалт хийх, түгээх, үйлчлэх, хооллох зэрэг сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний бүх шат дамжлага, сургуулийн орчинд худалдаалахыг хориглосон хүнсний бүтээгдэхүүн худалдан борлуулж буй эсэх зэрэг хамаарагдана.

2.2.Сургуулийн захирал нь Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний тухай хуулийн 6.1-д заасныг баримтлан хоол үйлдвэрлэл, үйлчилгээг зохион байгуулж, тогтмол хяналт тавьж ажиллана.

2.3.Сургуулийн захирал тухайн жилд хэрэгжүүлэх дотоод хяналтын нэгж/багийн төлөвлөгөөг баталж, биелэлтэд хяналт тавина. Төлөвлөгөөнд доор дурдсан асуудлыг тусган хэрэгжүүлнэ:

2.3.1.дотоод хяналт хийх хугацаа, ажилтны хуваарь, тайланг сургуулийн удирдлагын зөвлөл, нийт ажилчдын хуралд хэлэлцүүлэх;

2.3.2.дотоод хяналтын үр нөлөөг нэмэгдүүлэх болон нэгж/багийн чадавхыг дээшлүүлэх зорилгоор холбогдох байгууллагаас мэргэжил арга зүйн зөвлөгөө авах, хамтран ажиллах талаар;

2.3.3.хоолны хордлого, халдвар гарсан тохиолдолд шуурхай хариу арга хэмжээ авах болон гарч болох эрсдэл, түүнээс урьдчилан сэргийлэх талаар мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, ажилтнуудад сургалт зохион байгуулах;

2.3.4.өөрийн байгууллагад холбогдох дүрэм, журам, стандартын хэрэгжилтэд үнэлгээ, судалгаа хийх, санал боловсруулж холбогдох газарт хүргүүлэх;

2.3.5.орон тооны бус хяналтын зөвлөл болон эцэг, эх асран хамгаалагчидтай хамтран ажиллах, санал, санаачилга, гомдлын дагуу хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

2.4.Энэхүү журмын 2.1-д заасан шат дамжлага бүрт хариуцсан ажилтан /хоол зүйч, эмч, тогооч, бэлтгэгч г.м/ өдөр тутмын хяналт хийж, бүртгэл хөтлөх бөгөөд дотоод хяналтын нэгж/баг нь тодорхой давтамжтай хяналтыг хэрэгжүүлнэ.

2.5.Сургууль, дотуур байрын хоол үйлдвэрлэл, үйлчилгээг нэгтгэн зохион байгуулж, хяналтыг хэрэгжүүлж болох бөгөөд энэ тохиолдолд 2.4-д заасныг баримтална.

2.6.Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлын шалтгаан нөхцөлийг тодруулан, зөрчлийг арилгуулах, дахин гаргуулахгүй байх арга хэмжээ авч, урьдчилан сэргийлэх талаар сургалт зохион байгуулж, “Ажиллагсдад сургалт хийсэн бүртгэл”-ийг хөтөлнө.

2.7.Дотоод хяналтын нэгж/баг, энэхүү журмын 1.4-д заасан холбогдох ажилтнууд дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдал, үүсч болзошгүй эрсдэлийн талаарх мэдээллээр сургуулийн удирдлагыг хангаж ажиллана.

2.8.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээтэй холбоотой санал хүсэлт ирсэн тохиолдолд дотоод хяналтын нэгж/баг хүлээн авч, хяналт хийн, залруулах арга хэмжээг удирдан зохион байгуулж, “Санал, хүсэлт, авсан арга хэмжээний бүртгэл”-ийг хөтөлнө.

2.9.Хоол, хүнсний бүтээгдэхүүн нь чанар, эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хүүхдийн эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлсэн болон үзүүлж болзошгүй нөхцөл үүссэн зөрчлийг дотоод хяналтаар илрүүлсэн тохиолдолд хоол үйлдвэрлэл, үйлчилгээг түр зогсоон, удирдлагад шуурхай танилцуулж, хяналтын байгууллагад мэдэгдэн, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

2.10.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд хяналтын байгууллагаас

өгсөн үүрэг, чиглэлийн дагуу үүссэн нөхцөл байдал, эрсдэлийг арилгах арга хэмжээг шуурхай хэрэгжүүлж ажиллана.

**Гурав.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалахад тавих хяналт**

3.1.Дотоод хяналтын нэгж/баг нь “Сургалтын байгууллагын хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам”-д заасны дагуу тухайн жилд шаардлагатай хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хэрэгцээг тооцсон байдал, нийлүүлэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилт, захиалга хийж буй үйл явц, шаардлага хангасан бүтээгдэхүүнийг нийлүүлж буй эсэхэд хяналт тавьж ажиллана.

3.2.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авах, хадгалахад тавих өдөр тутмын хяналтыг хоол зүйч (нярав) хэрэгжүүлнэ.

3.3.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа “Сургалтын байгууллагын хүүхдийн хоол, хүнсний хангамж, үйлчилгээ үзүүлэх журам”-д заасан нийлүүлэгчид тавигдах шаардлагаас гадна чанар, аюулгүй байдлын баталгаажилт, тоо хэмжээ, сав, баглаа боодолд дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

3.3.1.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний гарал үүслийн болон чанар, аюулгүй байдлыг тодорхойлуулсан итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээний дүнгийн хуудсыг бүтээгдэхүүний нэр, төрөл, цувралын дугаар, үйлдвэрлэсэн огноогоор тулгах;

3.3.2.захиалгын дагуу хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг нэр төрөл, тоо хэмжээгээр нийлүүлсэн эсэх;

3.3.3.зориулалтын сав, баглаа боодолд савласан, бүрэн бүтэн байдал, битүүмжлэл алдагдсан эсэх;

3.3.4.хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хаяг шошгод Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.4-т заасан мэдээлэл бүрэн тусгагдсан эсэх;

3.3.5.хагас боловсруулсан бүтээгдэхүүн хүлээн авч буй тохиолдолд бүтээгдэхүүний шошгод гүйцэд боловсруулах аргачлалыг тусгасан эсэх.

3.4.Энэхүү журмын 3.3-т заасан дотоод хяналтыг хэрэгжүүлж, шаардлага хангасан тохиолдолд “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэл”-ийг хөтөлж хүлээн авна.

3.5.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авахад энэ журмын 3.3-т заасан шаардлагыг зөрчсөн тохиолдолд “Хүнсний түүхий эд, материал буцаах бичиг”-ийг хөтлөн, буцааж, шаардлага хангасан бүтээгдэхүүнийг ажлын 3 хоногт нөхөн нийлүүлэх арга хэмжээг авхуулна.

3.6.Энэхүү журмын 3.4-т заасан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн нь хүний эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй нөхцөл байдал

илэрсэн бол хяналтын байгууллагад заавал мэдэгдэнэ.

3.7. Хүлээн авсан хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтад дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

3.7.1. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн бүрийн шинж чанар, хадгалах горим, нөхцөлийг харгалзан зориулалтын агуулах, хөргөгч, хөлдөөгчид ангилан хадгална;

3.7.2. агуулахад хадгалж буй хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалах болон дуусах хугацаа, хадгалалтын хэмийн өдөр тутам хяналтыг “Бичил цаг уурын бүртгэл”, “Хөргүүртэй агуулах, хөргөх төхөөрөмжийн хэмийн бүртгэл”-д тогтмол хөтөлнө;

3.7.3. агуулахаас эхэлж орсон нь түрүүлж гарах зарчмыг баримтлан, хоол үйлдвэрлэлд ашиглах хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн болон хагас боловсруулсан бүтээгдэхүүн /хоолны бэлдэц/-ийг хүлээн авч, түр хадгалалтад тогооч хяналт тавьж, энэхүү журмын 3.7.2-т заасан бүртгэлүүдийг хөтөлнө.

3.8. Хадгалалтын явцад хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний сав, баглаа боодлын бүрэн бүтэн байдал алдагдсан, хугацаа дууссан тохиолдолд шаардлага хангахгүй бүтээгдэхүүний хаягтай тавиурт байрлуулан, дотоод хяналтын нэгж/багт мэдээлнэ.

3.8.1. дотоод хяналтын нэгж/баг энэхүү журмын 3.6-т заасан шаардлага хангахгүй болсон шалтгааныг хянаж, сургуулийн удирдлагад танилцуулан, холбогдох журмын дагуу акт үйлдэн, устгах үйл ажиллагаанд хяналт тавина;

3.8.2. хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хадгалах явцад шаардлага хангахгүй болсон шалтгааны буруутай албан тушаалтанд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцон, дотоод хяналтын нэгж/баг алдаа дутагдлыг дахин давтан гаргахаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулна.

### **Дөрөв. Хоол үйлдвэрлэл, түгээх, үйлчлэхэд тавих хяналт**

4.1. Хоол үйлдвэрлэлийн бэлтгэл, дулааны боловсруулалтын шатанд тогооч дараах хяналтыг хэрэгжүүлнэ:

4.1.1. хүнсний түүхий эд бүтээгдэхүүний анхан шатны боловсруулалт (угаах, ангилах, хэрчих, жижиглэх, бэлтгэх)-ад үйл ажиллагааны дараалал, боловсруулалтад оруулах хугацаа, ашиглаж буй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн угаалга цэвэрлэгээ, аюулгүй байдалд тогооч хяналт тавьж ажиллана;

4.1.2. хоол үйлдвэрлэлийн шат дамжлагад технологийн горим баримталж буй эсэх, хадгалалт, түгээх үеийн хэмд ахлах тогооч хяналт тавьж, “Хоол бэлэн болсон цаг, хэмийн бүртгэл”-ийг тогтмол хөтөлнө;

4.1.3. нэг ээлжид бэлтгэсэн бүх төрлийн хоол хүнснээс холбогдох стандартын дагуу дээж авах, хадгалах, устгах ба “Хоол, бүтээгдэхүүний

дээжийн бүртгэл”-ийг хөтөлнө. Дээж авах, хадгалах, устгах бүртгэлийг ахлах тогооч хөтөлж, хоол зүйч/эмч хяналт тавьж ажиллана.

4.2.Хоол зүйч/эмч нь хоол үйлдвэрлэл батлагдсан цэс, технологийн картын дагуу явагдаж буй эсэхэд хяналт тавьж, хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний орц, гарцын хэмжээг тулган хянаана.

4.3.Хоол түгээх, үйлчлэх шатанд хоол зүйч/эмч, тогооч хяналт тавьж ажиллах бөгөөд анги, танхимаар хооллох тохиолдолд ангийн багш дэмжлэг үзүүлж ажиллана.

4.4.Бэлтгэсэн хоолны савлагаа (зориулалтын халуун барих саванд савлах), порц, тоо хэмжээ, түгээлтэд гарах болон олгох үеийн хэмд ахлах тогооч, хоол зүйч/эмч хяналт тавих ба “Хоол, бүтээгдэхүүний түгээлт, чанарын хяналтын бүртгэл”-ийг хөтөлнө.

4.5.Хоол зүйч/эмч нь хоолыг нэгдсэн заалаар бус анги танхимд үйлчилдэг бол савлагаа, битүүмжлэл, тээвэрлэлт, олгож буй хугацаа, хоолны хэм, порцлолт, суралцагчийн гар угаалгах үйл ажиллагаа, аяга, тавгийн цэвэр байдал, хоолны үлдэгдэл, устгалд хяналт тавина.

#### **Тав.Цэвэрлэгээ, халдваргүйтгэл, ажиллагсдын ариун цэвэр, эрүүл мэндэд тавих хяналт**

5.1.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний цэвэрлэгээ, халдваргүйтгэл, шавж, мэргэч устгалын үйл ажиллагаа, үр дүн, тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээ, бүртгэлийг ахлах тогооч өдөр тутамд, хоол зүйч/эмч, тодорхой давтамжтайгаар, дотоод хяналтын нэгж/баг батлагдсан төлөвлөгөө, хуваарийн дагуу, шаардлагатай тохиолдолд тухай бүр хяналт тавьж ажиллах ба зөрчил дутагдал илэрсэн бол арилгуулах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

5.2.Энэхүү журмын 5.1-д заасан үйл ажиллагааны явцад “Түүхий эд, бүтээгдэхүүн хүлээн авах болон хадгалах өрөөнд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн тухай бүртгэл”, “Бэлтгэлийн болон дулааны боловсруулалтын өрөөнд цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн тухай бүртгэл”, “Хоол олгох хэсэг, хоолны багаж, хэрэгсэл, тээврийн хэрэгсэл, тэргэнцэрт цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн тухай бүртгэл”, “Хортон шавж, мэргэчийн устгал хийлгэсэн тухай бүртгэл”, “Тоног төхөөрөмжийн засвар, үйлчилгээний бүртгэл”-ийг цаасан болон цахим хэлбэрээр тогтмол хөтөлнө.

5.3.Сургуулийн эмч нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнтэй харьцдаг, боловсруулдаг, үйлчилгээ үзүүлдэг (хоол зүйч, нярав, тогооч, бэлтгэгч, дотуур байрын багш, бага ангийн багш зэрэг) ажилтныг холбогдох журамд заасны дагуу эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулж, баталгаажуулалтын байдалд хяналт тавьж, хугацаа дуусахаас өмнө давтан үзлэг, шинжилгээнд хамруулах ажлыг зохион байгуулна.

5.3.1.үзлэг шинжилгээний дүн “эерэг” гарсан бол захиралд танилцуулж, эмчилгээнд хамруулах эрүүлжүүлэх, хөдөлмөр зохицуулалт хийх асуудлыг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу гүйцэтгэн, ажилчдад тогтмол сургалт зохион байгуулна.

5.4.Ахлах тогооч нь хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажиллагсдын хувийн ариун цэвэр, хөдөлмөр хамгааллын хувцасны угаалга, цэвэрлэгээ, хэрэглээ, гар угаах болон ажилтны өвчлөл, осол гэмтэлд өдөр тутам хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд сургуулийн эмчид мэдээлэн, холбогдох арга хэмжээ авхуулах ба “Ажилтны эрүүл мэнд, ариун цэврийн үзлэгийн бүртгэл”, “Өвчний шинж тэмдгийг бүртгэх бүртгэл”-ийг хөтөлнө.

5.5.Ажилтан эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдсан боловч холбогдох журамд заасан дараагийн үзлэгт хамрагдах хугацаа болоогүй байхад халдварт өвчнөөр өвчилсөн эсхүл өвчтөн асарсан тохиолдолд ажилдаа буцаж орохоос өмнө эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд хамрагдаж, эрүүл эсэхээ баталгаажуулсан магадалгаа гаргуулсан эсэхэд сургуулийн эмч хяналт тавьж энэхүү журмын 5.4-д заасан бүртгэлийг хөтөлнө.

### **Зургаа.Тайлагнах үйл ажиллагаа**

6.1.Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний дотоод хяналтын нэгж/баг эсхүл ажилтан нь дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

6.1.1.Дотоод хяналтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнг сургуулийн удирдлагад тухай бүр танилцуулж, зохих шийдвэр гаргуулан хэрэгжилтийг хангуулах арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллана;

6.1.2.Илэрсэн зөрчлийг арилгаагүй, хууль ёсны шаардлагыг эсэргүүцсэн, тогтоосон хугацаанд биелүүлээгүй, шаардлагын биелэлтийг гаргаагүй ажилтанд хариуцлага ногдуулах саналыг байгууллагын удирдлагад тавьж шийдвэрлүүлэх, шаардлагатай тохиолдолд хууль, хяналтын байгууллагад мэдээлнэ;

6.1.3.Дотоод хяналтын үйл ажиллагааны тайланг хагас, бүтэн жилээр гаргаж, сургуулийн удирдах зөвлөлд танилцуулж, хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үйл ажиллагааг сайжруулах төлөвлөлт, зохион байгуулалтыг хийнэ.

6.2.Сургуулийн захирал дотоод хяналтын тайланг жилд 1-ээс доошгүй удаа нийт ажилтны хуралд танилцуулж, “Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээнд тавих хяналтын журам”-д заасны дагуу боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ.

6.3.Энэхүү журмын 6.2-т заасан байгууллага нь сургуулиудаас ирүүлсэн дотоод хяналтын тайланг хүлээн авч, холбогдох

байгууллагатай хамтран хяналт, үнэлгээ хийж, дүнг боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад жил бүрийн 12 дугаар сард хүргүүлнэ.

6.4.Дотоод хяналтыг хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг архивын нэгж үүсгэн байгууллагын архивт хүлээлгэн өгч, мэдээллийн сан бүрдүүлнэ.

#### **Долоо.Хариуцлага**

7.1.Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын шинж байдлаас хамааран буруутай этгээдэд холбогдох хууль тогтоомж, тухайн аж ахуйн нэгж, байгууллагын дотоод журамд заасан хариуцлагыг ногдуулна.

7.2.Дотоод хяналт шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал нь зөрчил, гэмт хэргийн шинжтэй бол асуудлыг хууль, хяналтын байгууллагад тавьж шийдвэрлүүлнэ.

*“Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний  
дотоод хяналтын журам”-ын хавсралт*

**ДОТООД ХЯНАЛТЫН БҮРТГЭЛИЙН ЗАГВАР**

1.Ажлын байр, тоног төхөөрөмжийн өдөр тутмын цэвэрлэгээ, халдваргүйтгэл, засвар үйлчилгээний талаарх бүртгэлийн загвар:

**ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮН ХҮЛЭЭН АВАХ, ХАДГАЛАХ ӨРӨӨ /АГУУЛАХ/-НД ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙСЭН ТУХАЙ БҮРТГЭЛ**

Хүснэгт 1

Он, сар, өдөр, цаг минут	Түүхий эд хүлээн авах хэсэг		Түүхий эд, бүтээгдэхүүн хадгалах хөргүүртэй өрөө, камер, хөргөлтийн тоног төхөөрөмжүүд		Бусад агуулах /хуурай бүтээгдэхүүн, мах, ногоо г.м-ээр/		Гүйцэтгэсэн ажилтны нэр, гарын үсэг	Хянасан хүний нэр, гарын үсэг
	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн		

Хянах арга: Хүснэгт 1-3-т заасан цэвэрлэгээ хийсэн гэсэн хэсэгт цэвэрлэгээ, халдваргүйтгэл хийсэн бодисын нэр, уусмалын хувийг тэмдэглэнэ. Хяналт хийсэн гэсэн хэсэгт халдваргүйтгэлд ашигласан бодисыг зааврын дагуу найруулж, хэрэглэж буй эсэхийг хянаж Хүснэгт 3-ын доор тусгасан тэмдэглэгээг тавина.

**БЭЛТГЭЛИЙН БОЛОН ДУЛААНЫ БОЛОВСРУУЛАЛТ /ГАЛ ТОГОО/-ЫН ӨРӨӨНД ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ ХИЙСЭН ТУХАЙ БҮРТГЭЛ**

Хүснэгт 2

Он, сар, өдөр, цаг минут	Мах бэлтгэлийн цех /хэсэг/, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл		Ногоо бэлтгэлийн цех /хэсэг/, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл		Талх, нарийн боовны цех /хэсэг/, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл		Дулааны боловсруулалтын /гал тогоо/ цех /хэсэг/, тоног төхөөрөмж		Гүйцэтгэсэн ажилтны нэр, гарын үсэг	Хянасан хүний нэр, гарын үсэг
	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн		

**ХООЛ ОЛГОХ ХЭСЭГ, ХООЛНЫ БАГАЖ, ХЭРЭГСЭЛ, ТЭЭВРИЙН  
ХЭРЭГСЭЛ, ТЭРГЭНЦЭРТ ЦЭВЭРЛЭГЭЭ, ХАЛДВАРГҮЙТГЭЛ  
ХИЙСЭН ТУХАЙ БҮРТГЭЛ**

Хүснэгт 3

Он, сар, өдөр, цаг минут	Хоолны хэрэгсэл угаалгын өрөө /хэсэг/, тоног төхөөрөмж, хэрэгсэл*		Хоол олгох хэсэг, сав багаж хэрэгсэл		Хоол, хүнсийг тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл		Гүйцэтгэсэн хүний нэр, гарын үсэг	Хянасан хүний нэр, гарын үсэг
	Цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийсэн	Хяналт хийсэн	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн	Цэвэрлэгээ хийсэн	Хяналт хийсэн		

Хянах арга: \*Цэвэрлэгээ, халдваргүйтгэлийн хяналтыг сургуулийн хоол зүйч эсхүл эмч хийнэ. Угааж, ариутгасан хоолны сав багаж хэрэгсэл, аяга тавгийн угаалга, ариутгал, халдваргүйтгэл сайн байвал 0, муу байвал X, дутуу байвал Δ гэх зэргээр тэмдэглэнэ. Дээрх угаалга, ариутгал, халдваргүйтгэл хангалтгүй хийгдсэн тохиолдолд дахин хийлгэнэ.

**ХОРТОН ШАВЖ, МЭРЭГЧИЙН УСТГАЛ ХИЙЛГЭСЭН БҮРТГЭЛ**

Хүснэгт 4

Огноо	Устгал хийсэн байгууллагын нэр	Устгал хийлгэсэн газар, цехийн нэр	Хэрэглэсэн бодис, уусмалын нэр	Устгал хийсэн актын дугаар	Гарын үсэг

**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЗАСВАР, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БҮРТГЭЛ**

Хүснэгт 5

Газар, цехийн нэр	Засвар, үйлчилгээ хийсэн		Хийсэн засвар, үйлчилгээний талаарх мэдээлэл	Засвар үйлчилгээ хийсэн байгууллага, ажилтны нэр	Шалгаж, хүлээн авсан ажилтны нэр, гарын үсэг
	Тоног төхөөрөмжийн нэр	Огноо			

2.Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний ажиллагсдын ажлын хувцас, хувийн эрүүл мэнд, эрүүл ахуйг хянах бүртгэлийн загвар:

## АЖИЛТНЫ ЭРҮҮЛ МЭНД, АРИУН ЦЭВРИЙН ҮЗЛЭГИЙН БҮРТГЭЛ

Ажилтны овог, нэр: .....

Албан тушаал: .....      .... оны .... -р сарын .... -р долоо хоног  
Хүснэгт 6

№	Үзүүлэлт	Гараг				
		Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан
1	Ажлын хувцас, хэрэгслийг бүрэн өмссөн эсэх					
2	Ажлын хувцасны ариун цэвэр					
3	Гар, хуруу, хумсны ариун цэвэр					
4	Үс гээг далдалсан эсэх					
5	Ээмэг, бөгж, бугуйн цаг хэрэглэсэн эсэх					
6	Арьс салст гэмтэж шархалсан эсэх					
7	Халуурсан болон өвчний ямар нэг зовиуртай эсэх					
8	Халдварт өвчнөөр өвчилсөн эсвэл өвчтэй хүн асарсан эсэх					

Хянах арга: Хоол хүнстэй шууд харьцагч ажилтан тус бүрт хөтөлнө. Үзлэгийг ажил эхлэхийн өмнө ахлах /ерөнхий/ тогооч эсвэл эрүүл ахуйч, эмч хийнэ. Зөрчилтэй бол “Х”, зөрчилгүй бол “-” гэж тэмдэглэнэ. Халуурсан болон өвчний ямар нэг зовиуртай байгаа тохиолдолд сургуулийн эмч Өвчний шинж тэмдгийг бүртгэх бүртгэлийг хөтөлж, холбогдох арга хэмжээг авч ажиллана.

### ӨВЧНИЙ ШИНЖ ТЭМДГИЙГ БҮРТГЭХ БҮРТГЭЛ

Ажилтны овог, нэр: .....

Албан тушаал: .....

Гэрийн хаяг: .....

..... оны ....-р сарын ..... өдөр

## ӨВЧНИЙ ШИНЖ ТЭМДГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Хүснэгт 7

Илэрсэн шинж тэмдэг	Тийм	Үгүй	Шинж тэмдэг илэрсэн он, сар, өдөр, цаг, минут
Бөөлжсөн			
Суулгасан			
Удаан хугацаанд ханиалгасан			
Халуурсан			
Нүд, чих, хамраас шингэн ялгадас гоожсон			
Арьс салст гэмтэж шархалсан			

Эдгээр асуултын заримд нь та ТИЙМ гэж хариулсан бол өөрийн өвчний байдлын талаар бичнэ үү:

.....

Дээрх хариултууд нь үнэн зөв болохыг баталж байна.

Ажилтны гарын үсэг, он, сар, өдөр: .....

Эмнэлгийн үзлэгт орох зайлшгүй шаардлагатай эсэх /эмч бөглөнө/:

ТИЙМ ҮГҮЙ

Авсан арга хэмжээ: .....

Эмчийн гарын үсэг, он, сар, өдөр, цаг, минут: .....

3. Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн загвар:

### ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ УЛ МӨРИЙГ МӨРДӨН ТОГТООХ БҮРТГЭЛ

..... ОН ..... сар .... өдөр ..... гараг  
Хүснэгт 8

Ангилал	Түүхий эд, бүтээгдэхүүний нэр	Өмнөх үлдэгдэл хэмжээ /кг, ширхэг/	Нийлүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Гарал үүслийн гэрчилгээ, лабораторийн шинжилгээний харуу, баримтын дугаар, огноо	Хүлээн авсан тоо, хэмжээ /кг, ширхэг/	Буцаасан байдал*		Хоол үйлдвэрлэлд хэрэглэсэн байдал		Үлдэгдэл хэмжээ /кг, ширхэг/
						Буцаасан шалтгаан	Хэмжээ /кг, ширхэг/	Сурагчийн тоо	Хэрэглэсэн хэмжээ /кг, ширхэг/	
Махны төрөл	Үхрийн мах									
	.....									
Үр тарианы төрөл Г.М	Гурил									
	.....									

\*хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг хүлээн авахдаа стандарт, чанарын шаардлага хангахгүй тохиолдолд нийлүүлэгч байгууллагад буцаах арга хэмжээ авах бөгөөд дараах бичгийг хөтөлнө.

### ХҮНСНИЙ ТҮҮХИЙ ЭД, МАТЕРИАЛ БУЦААХ БИЧИГ

Хүснэгт 9

Сургуульд үлдэх хуудас	Хүнсний түүхий эд, материал буцаах бичиг № .....
	Бараа, бүтээгдэхүүн нийлүүлсэн байгууллагын нэр: .....
	Бараа, бүтээгдэхүүн нийлүүлсэн өдөр: .....
	Барааны нэр төрөл, тоо хэмжээ: .....
	Буцаах болсон шалтгаан: .....
	Баталгаажуулсан: .....
	..... /албан тушаал/ .....
	..... /овог, нэр/ .....
	..... /гарын үсэг/ .....

4.Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний хадгалалтын горимын мөрдөлтийг хянах бүртгэлийн загвар:

**ХӨРГҮҮРТЭЙ АГУУЛАХ /КАМЕР/, ХӨРГӨХ ТӨХӨӨРӨМЖИЙН  
ХЭМИЙН БҮРТГЭЛ**

..... он ..... сар ..... өдөр  
Хүснэгт 10

Гараг	Хөргүүртэй агуулах /камер/ №1, 2... /махны, цагаан идээний гэх зэргээр бүтээгдэхүүнээр нь ялгаж болно/	Хөлдөөгч №1, 2... /махны, сүү, цагаан идээний гэх зэргээр бүтээгдэхүүнээр ялгаж болно/	Хөргөгч №1, 2... /сүүний, ногооны гэх зэргээр бүтээгдэхүүнээр ялгаж болно/	Хоолны дээжийн хөргөгч	Тэмдэглэл хөтөлж бүртгэсэн хугацаа, ажилтны нэр
Даваа /өглөө орой/					
Мягмар /өглөө орой/					
Лхагва /өглөө орой/					
Пүрэв /өглөө орой/					
Баасан /өглөө орой/					

Хянах арга:

1. Хөргөгч, хөргүүр, камерын хэм 0-аас +5<sup>0</sup>, хөлдөөгчийн хэм -18<sup>0</sup>-аас доош байна.
2. Хөргөх төхөөрөмжүүдийн хэмийг ахлах /ерөнхий/ тогооч шалгаж бүртгэнэ.
3. Хөргөх төхөөрөмжүүдийн хэмийг өдөр бүр 2 удаа /ажил эхлэх болон ажил дуусах үед/ хянаж бүртгэх бөгөөд тухайн үеийн хэмийг хүснэгтийн нүдэнд гаргацтай тэмдэглэнэ.
4. Хөргөх төхөөрөмжүүдэд зориулалтын термометр байрлуулсан байна.
5. Бүртгэлийн хуудсыг хөргөх төхөөрөмжүүдийн гадна талд байрлуулсан байна.
6. Сарын эцэст бүртгэлийн хуудсыг сольж, өмнөх хуудсыг хадгална.

## БИЧИЛ ЦАГ УУРЫН БҮРТГЭЛ

Хоол, хүнс хадгалах, бэлтгэх боловсруулах өрөөний нэр: .....

Хүснэгт 11

Гараг	Харьцангуй чийг /хувиар/	Өрөөний хэм /°C/	Гэрэлтүүлэг /люкс/	Агааржуулалтын систем хэвийн ажиллагаатай эсэх	Тэмдэглэл хөтөлж бүртгэсэн хугацаа, ажилтны нэр
Даваа					
Мягмар					
Лхагва					
Пүрэв					
Баасан					

Хянах арга:

1. Хоол, хүнс хадгалах /ногооны, хуурай хүнсний агуулах г.м/, бэлтгэх, боловсруулах, савлах, түгээх зэрэг бүх өрөө /хэсэг/ тус бүрт бүртгэл хөтөлнө.
2. Бүртгэлийг томилогдсон ажилтан шалгаж бүртгэнэ.

5.Хоолны дээжийн бүртгэлийн загвар:

**ХООЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ДЭЭЖИЙН БҮРТГЭЛ**

Хүснэгт 12

Огноо	Хоол, бүтээгдэхүүний нэр	Хоол хийсэн тогооч	Хоол болсон цаг, минут	Дээжийн хэмжээ /грамм, мл/	Дээж авах үеийн хөргөгчийн хэм	Түгээсэн хүүхдийн тоо	Дээж устгасан огноо, цаг, минут	Дээж устгах үеийн хөргөгчийн хэм	Хянасан ажилтны гарын үсэг
1-р ээлж									
2-р ээлж									

Хянах арга:

1. Дээжийн зориулалтын сав, хөргөгч тусдаа байна.
2. Хүүхдийн хоол, хүнсэнд олгосон хоол, бүтээгдэхүүн тус бүрээс дээж авч, бүртгэл хөтөлнө. Дээжний хэмжээ 150 гр-аас доошгүй байна.
3. Дээж тус бүрд хоолны дээж хадгалах бичгийг хөтлөн хадгална.
4. Дээжийг 72 цаг хадгална.
5. Бүртгэлд хоол зүйч эсвэл сургуулийн эмч хяналт тавина.

**ХООЛНЫ ДЭЭЖ ХАДГАЛАХ БИЧИГ**

Хүснэгт 13

Хадгалсан өдөр	Он, сар, өдөр: Цаг, минут:
Хоол, бүтээгдэхүүний нэр:	
Дээж авсан хүний нэр:	
Устгах хугацаа:	Он, сар, өдөр: Цаг, минут:

6. Бэлэн гарсан хоол, хүнсний чанар, түгээлтийн үеийн бүртгэлийн загвар:

### ХООЛ БЭЛЭН БОЛСОН ЦАГ, ХЭМИЙН БҮРТГЭЛ

Хүснэгт 14

Огноо	Хоолны нэр	Хоол бэлэн болсон цаг, минут	Хэм	Хоол хийсэн тогоочийн нэр, гарын үсэг
1-р ээлж				
2-р ээлж				

### ХООЛ, БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ТҮГЭЭЛТ, ЧАНАРЫН ХЯНАЛТЫН БҮРТГЭЛ

..... он ..... сар ..... өдөр

Хүснэгт 15

Ээлж	№	Анги	Сурагчийн тоо	Хоол түгээсэн /олгосон/ цаг, минут	Хоол түгээсэн /олгосон/ хэм	Хоол түгээсэн /олгосон/ ажилтан, гарын үсэг	Хүүхдийн хооллох байдал, үлдэгдлийн хэмжээ	Хянасан ажилтны гарын үсэг
1-р ээлж	1							
	2							
	3							
2-р ээлж	1							
	2							
	3							

Хянах арга:

1. Хоол бэлэн болсон даруйд түгээх бөгөөд бэлэн болсон хоолыг зориулалтын хоол халуун байлгагчид хадгалах хугацаа 2 цагаас хэтрэхгүй байна.
2. Хоол олгох хэм 1-р хоол +75°C, 2-р хоол +65°C-аас доошгүй байгаа эсэхийг шалгана.
3. Хоол түгээж, олгож буй ажилтан ажлын хувцас, хамгаалах хэрэгслийг /амны хаалт, бээлий г.м/ бүрэн өмссөн байна.
4. Бүртгэлийг хоол зүйч, сургуулийн эмч, ангид хооллож буй тохиолдолд ангийн багш хянана.

5. Хүүхдийн хооллох байдал, үлдэгдлийн хэмжээг 7 хоногт 1 удаа түүвэрчилсэн байдлаар хоол зүйч хянаж бүртгэх бөгөөд уг хяналтыг хийснээр хүүхдийн хоол шим тэжээлийн боловсролыг дээшлүүлэх, хоолны цэс төлөвлөлтөд ашиглана.

7. Ажиллагсдад сургалт хийсэн бүртгэлийн загвар:

### АЖИЛЛАГСДАД СУРГАЛТ ХИЙСЭН БҮРТГЭЛ

Хүснэгт 16

№	Сургалтын нэр, агуулга	Сургалт хийсэн сар, өдөр, үргэлжилсэн хугацаа	Сургалтыг зохион байгуулсан газрын нэр	Сургалт хийсэн хүний албан тушаал, нэр	Сургалтад оролцсон албан тушаалтан	Хянаж бүртгэсэн ажилтан

8. Хоол хүнстэй холбоотой санал, хүсэлтийн бүртгэлийн загвар:

### САНАЛ ХҮСЭЛТ, АВСАН АРГА ХЭМЖЭЭНИЙ БҮРТГЭЛ

Хүснэгт 17

№	Он, сар, өдөр, цаг минут	Санал, хүсэлт гаргасан байгууллага, иргэн	Санал, хүсэлтийн агуулга	Хянасан ажилтан	Хариуцсан ажилтан	Засч залруулах арга хэмжээ авсан байдал

Хянах арга:

1. Санал, хүсэлт ирсэн тохиолдолд хяналт хийх ажилтан /ахлах тогооч, хоол зүйч, эмч зэрэг/ танилцан холбогдох ажилтанд хариуцуулан залруулах арга хэмжээг авна. Арга хэмжээ авч ажилласан талаар тэмдэглэл хөтөлнө.

## **ХОВД АЙМАГ БУЛГАН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2026 оны 5 дугаар  
сарын 06-ны өдөр

Дугаар А/90

Бүрэнхайрхан

### **ӨВӨЛЖӨӨ, ХАВАРЖААНЫ БЭЛЧЭЭРИЙГ ЗУНЫ УЛИРАЛД МАЛААС ЧӨЛӨӨЛӨХ ХУГАЦАА ТОГТООХ ТУХАЙ**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.4.7 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Багуудын иргэдийн саналыг үндэслэн бэлчээрийг зохистой ашиглах, хамгаалах, талхлалтаас урьдчилан сэргийлэх, зорилгоор өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зуны улиралд малаас чөлөөлөх хугацааг жил бүрийн 06 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 25-ныг хүртэл хугацаанд тогтоосугай.

2.Өвөлжөө, хаваржааны бэлчээрийг зуны улиралд малаас чөлөөлж, тогтоосон хугацаа шаардлагыг зөрчсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын дагуу зохих хариуцлага тооцож, арга хэмжээ ажиллахыг холбогдох албан тушаалтнуудад үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч, малчин болон мал бүхий иргэдэд мэдээлэл хүргэж ажиллахыг багийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ГАНТУЛГА

## **ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ТУШААЛ**

2026 оны 5 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар А/136

Улаанбаатар  
хот

### **ЖУРАМ БАТЛАХ ТУХАЙ**

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төмөр замын тээврийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.17, 11.2-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг төмөр замын тээврийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, төмөр замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч этгээдэд даалгасугай.

3. Журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Төмөр замын газар (Б.Артур), хяналт тавьж ажиллахыг Төмөр замын тээврийн бодлого зохицуулалтын газар (Х.Итгэлт)-т тус тус үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын 2026 оны А/74 дүгээр тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

САЙД

Б.ДЭЛГЭРСАЙХАН

*Зам, тээврийн сайдын 2026 оны 5 дугаар сарын 12-ны  
өдрийн А/136 дугаар тушаалын хавсралт*

## **ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ЖОЛООДОХ ЭРХ ОЛГОХ ЖУРАМ**

### **НЭГ.НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

1.1.Монгол Улсын төмөр замын хөдлөх бүрэлдэхүүний машинч бэлтгэх, нөөц бүрдүүлэх зорилгоор хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох шалгалт авах, эрх олгох, бүртгэл хөтлөхтэй холбогдсон харилцааг энэхүү журмаар зохицуулна.

1.2.Энэхүү журмыг төмөр замын тээврийн байгууллага болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч байгууллагууд мөрдөнө.

1.3.Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох шалгалтыг төмөр замын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (цаашид “төрийн захиргааны байгууллага” гэх) жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулна.

1.4.Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх авсан иргэд нь Монгол Улсад ашиглагдаж байгаа бүх серийн зүтгүүрийг жолоодох эрхтэй байна.

1.5.Төмөр замын тээврийн байгууллага, хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх горилж буй шаардлага хангасан иргэдийн материалыг төрийн захиргааны байгууллагад шалгалт эхлэхээс 14 хоногийн өмнө ирүүлнэ.

1.6.Жолоодох эрх авах горилогч нь Төмөр замын тээврийн салбарын мэргэжилтэй ажилтан сургах, давтан сургах, мэргэшүүлэх, мэргэжлийн зэрэг олгох журмын дагуу сургалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагын сургалтад хамрагдсан байна.

### **ХОЁР.ЭРХ ГОРИЛОГЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА**

2.1.Бакалавр болон түүнээс дээш зэрэгтэй бол мэргэжлээрээ 12-оос доошгүй сар тасралтгүй ажилласан байна.

2.2.Техникчийн зэрэгтэй бол мэргэжлээрээ 18-аас доошгүй сар тасралтгүй ажилласан байна.

2.3.Мэргэжлийн сургалтын байгууллага төгссөн бол мэргэжлээрээ 24-өөс доошгүй сар тасралтгүй ажилласан байна.

2.4.Мэргэжлийн сургалт төгссөн бол 30-аас доошгүй сар тасралтгүй ажилласан байна.

### **ГУРАВ.ШАЛГАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ**

3.1.Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгох шалгалтын үйл ажиллагааг төрийн захиргааны байгууллагаас томилогдсон мэргэжлийн шалгалтын комисс /цаашид “комисс” гэх/ зохион байгуулна.

3.2.Комисс нь 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байх ба

зүтгүүр, зүтгүүрийн аж ахуйн мэргэжлээр магистраас доошгүй зэрэгтэй, мэргэшсэн инженер, багш байна.

3.3.Комисс нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

3.3.1.шалгалтын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах;

3.3.2.шалгалт зохион байгуулах танхим, техник хэрэгслийн бэлэн байдлыг хангах;

3.3.3.шалгалттай холбоотой санал, гомдлыг хүлээн авч зохих журмын дагуу шийдвэрлэх;

3.3.4.шалгалтын үнэлгээ, тайлан, холбогдох материалыг төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх.

3.4.Шалгалтыг цахим хэлбэрээр зохион байгуулах ба бүртгүүлсэн иргэдийн тооноос хамаарч хэсэгчлэн зохион байгуулж болно.

3.5.Комисс шалгалтын тов болон холбогдох мэдээллийг шалгалт эхлэхээс хуанлийн 30-аас доошгүй хоногийн өмнө төрийн захиргааны байгууллагын цахим хуудас, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан нийтэд мэдээлнэ.

3.6.Зайлшгүй шаардлагаар шалгалтын тов болон мэдээлэлд өөрчлөлт оруулах бол энэ тухай шалгалт эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө нийтэд мэдээлнэ.

3.7.Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх горилогчид иргэний үнэмлэхээ шалгуулж шалгалтад орох бөгөөд дараах материалыг бүрдүүлнэ:

3.7.1.энэ журмын 2 дугаар зүйлд заасан шаардлагыг хангасан нотлох баримт;

3.7.2.цээж зураг 3x4 хэмжээтэй (файл);

3.7.3.шалгалтын хураамж төлсөн баримт;

3.7.4.эрүүл мэндийн тодорхойлолт.

3.8.Шалгалтыг Төмөр замын тээврийн тухай болон холбогдох хууль, дүрэм, журам, норм, стандарт, заавар, техникийн мэдлэг-засвар үйлчилгээ бүхий сургалтын хөтөлбөрийн хүрээнд 100 асуулттай тестээр 90 минутад багтааж зохион байгуулна.

3.9.Энэхүү журмын 3.8-т заасны дагуу шалгалтыг авах ба 80 буюу түүнээс дээш хувийн үнэлгээ авсан тохиолдолд хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх олгоно.

3.10.Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх авсан иргэний өөрийн эзэмшлийн зүтгүүр, хөдлөх бүрэлдэхүүн жолоодох зүгшрүүлэлтийг төмөр замын тээврийн байгууллага, өмчлөгч, эзэмшигч нь хариуцна.

3.11.Шалгалт зохион байгуулах, үнэмлэх олгохтой холбоотой үйл ажиллагааны зардлын хэмжээг төрийн захиргааны байгууллага тогтооно.

## **ДӨРӨВ.ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮН ЖОЛООДОХ ЭРХИЙН ҮНЭМЛЭХ ОЛГОХ, БҮРТГЭЛ ХӨТЛӨХ**

4.1.Төрийн захиргааны байгууллага нь хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэх /цаашид “үнэмлэх” гэх/ олгох үйл ажиллагаатай холбоотой дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

4.1.1.шалгалтад тэнцсэн иргэнд энэхүү журмын хавсралтаар баталсан үнэмлэхийн загварын дагуу үнэмлэх олгох;

4.1.2.үнэмлэхээ үрэгдүүлсэн тохиолдолд тухайн иргэний хүсэлтийг үндэслэн нөхөж олгоно.

4.2.Төмөр замын тээврийн байгууллага болон хөдлөх бүрэлдэхүүн өмчлөгч, эзэмшигч нь хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрхийн үнэмлэхтэй иргэнийг Төмөр замын тээврийн тухай хууль болон холбогдох дүрэм, журам зөрчсөн гэж үзвэл “Галт тэрэгний хөдөлгөөнтэй шууд холбоотой ажилтны хөдөлмөр эрхлэлтийн харилцаа, нөхцөл, сахилгын тусгай журам”-ын дагуу зохих арга хэмжээг авна.

4.3.Хөдлөх бүрэлдэхүүн жолоодох эрх олгохтой холбогдсон үнэлгээний хуудас, эрх олгосон, нөхөн олгосон талаарх мэдээллийг агуулсан бүртгэл, мэдээллийн сантай байх бөгөөд уг сан нь цахим хэлбэртэй байна.

